

БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛ

Mongolian
Economy


www.mongolianeconomy.mn

№01



БҮСЧИЛСЭН
ХӨГЖЛИЙН
ҮНДЭСНИЙ
ХҮРЭЭЛЭН

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН ШИНЭ ЗАГВАР



АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

MONGOLIA

БИЗНЕС, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Төр, хувийн
хэвшлийн түншлэл

БАРИМТ БИЧИГ

Монгол Улсын бүсчилсэн
хөгжлийн үзэл баримтлал

БҮСЧЛЭЛИЙН ТОГТОЛЦОО ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН 2024 ОНЫ 64
ДУГЭЭР ТОГТООЛООР
"БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН
ҮЗЭЛ БАРИМТЛАЛ"-ЫГ
ШИНЭЧЛЭН БАТЛАВ.



ХОЙД БҮС

БАЙГАЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧ,
ТӨРӨЛЖСӨН, АЖ ҮЙЛДВЭР

БАРУУН БҮС

ЭРЧИМ ХҮЧНИЙ ТӨРӨЛЖСӨН,
БАЙГАЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ДЭД БҮС

ХАНГАЙН БҮС

УЛАМЖЛАЛТ МАЛ АЖ АХУЙН
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ДЭД БҮС


ТӨВИЙН БҮС

ХӨДӨӨ АЖ АХУЙН ТӨРӨЛЖСӨН,
АЖ ҮЙЛДВЭРИЙН ДЭД БҮС

ЗҮҮН БҮС

ТҮҮХЭН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТӨРӨЛЖСӨН,
ЭРЧИМЖСЭН ХӨДӨӨ АЖ АХУЙН ДЭД БҮС

ЛАЛЫН
ИЙН ДЭД БҮС



УЛААНБААТАРЫН БҮС


ОЛОН УЛСЫН БАНК, САНХҮҮ,
БИЗНЕСИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ

ГОВИЙН БҮС

АЖ ҮЙЛДВЭРИЙН ТӨРӨЛЖСӨН,
НОГООН ЭРЧИМ ХҮЧНИЙ ДЭД БҮС

ТӨРӨЛЖСӨН,

Агуулга



05 РЕДАКЦЫН ЗУРВАС
“Бүсчилсэн хөгжил”
сэтгүүл мэндэллээ

06 МЭНДЧИЛГЭЭ
Бүсүүдийн тэргүүлэх 5
төслийг хамтдаа хэлэлцэж
эрэмбэлнэ

07 МЭНДЧИЛГЭЭ
Бүсчилсэн хөгжлийн
бодлогыг
хэрэгжүүлэхийн ач
холбогдол

08 ТҮҮХЭН ТОВЧОО
Монгол Улсын бүсчилсэн
хөгжлийн судлагдсан
байдал

10 ОНЦЛОХ НИЙТЛЭЛ
Бүсчилсэн хөгжлийн
бодлого хөгжлийн шинэ
загвар

14 ТООН МЭДЭЭЛЭЛ
16 ОНЦЛОХ ЯРИЛЦЛАГА
Монгол Улсын Шадар сайд
С.Амарсайхан:
Бүсчилсэн хөгжил
бол шинэ цагийн
сэргэн мандалтын
бодитой хэрэгжихүйц
бодлого юм

22 АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ
Go Mongolia

24 Орон нутгийн бүсчлэл-
хөгжлийн төвүүд

26 Тээвэр логиستيкийн
нэгдсэн сүлжээ байгуулна

28 БИЗНЕС, ХӨРӨНГӨ ОРЧУЛАЛТ
Төр, хувийн хэвшлийн
түншлэл

30 Бүс нутгийн эдийн
засгийн интеграцид
нэгдэж, зах зээлийг нээх
замаар хувийн хэвшлийг
борлуулалтаар дэмжинэ

32 БОДЛОГЫН БАЙР СУУРЬ

34 ХӨГЖЛИЙН БОДЛОГО
Д.Эрдэнэбаяр: Бүх түвшинд
нэгдсэн нэг ойлголттой
болж, нэг зүгт харж байж
Бүсчилсэн хөгжлийн
бодлого амжилттай
хэрэгжинэ

38 БАРИМТ БИЧИГ
Монгол Улсын бүсчилсэн
хөгжлийн үзэл баримтлал

40 ХАНГАЙН БҮС

46 БАРЧУН БҮС

52 ХОЙД БҮС

58 ТӨВИЙН БҮС

64 ЗҮҮН БҮС

72 ГОВИЙН БҮС

76 УЛААНБААТАРЫН БҮС

82 ИРГЭД, ОЛОН НИЙТИЙН САНАЛ

84 БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН



Mongolian
economy

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ: Д.БЭХБАЯР (9999 4248) | РЕДАКТОР: Н.ЭНХБАЯР | АНГЛИ РЕДАКТОР: РОБЕРТ ЙОХАН ШРАЙВЕРС
СЭТГҮҮЛЧИД: У.САРАНГЭРЭЛ, Б.ШҮРЭНЧИМЭГ | ДИЗАЙНЕР: Ш.ОЮУНДАРЬ, Г.ГАНЗОРИГ

ХАМТРАГЧ БАЙГУУЛЛАГА:



БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

МАРКЕТИНГИЙН АЛБА: 9409 2904

“БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛ” СЭТГҮҮЛ МЭНДЭЛЛЭЭ



Монгол Улсын төр шинэ хөгжлийн загвар гаргаж, бүсчилсэн хөгжлийн бодлогыг тодорхойлж, эрх зүйн орчныг богино хугацаанд бүрдүүллээ. Цаасан дээр байсан бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал амь орж, хурдтай урагшлахаар боллоо. Улсаараа, бүсээрээ, аймгаараа, сумаараа нэгдэж, нийлж, хоршиж, дагнаж ажилласнаар улс орноо хурдтай хөгжүүлнэ гэсэн гол зорилгод бүгд зангидагдаж байна.

“Бид одоо л хөгжлийн зөв загвараа гаргаж, хөгжлийн зөв зам дээрээ гарч ирлээ” гэж улстөрчид, намууд, хувийн хэвшил, эрдэмтэн судлаачид хүлээн авч байна.

“Mongolian Economy” сэтгүүлийн зүгээс бүсчлэн хөгжихийг дэмжиж, энэхүү бодлогыг хэрэгжихэд олон нийтэд мэдээллийн үүрэг гүйцэтгэж ажиллахаа илэрхийлж, “Бүсчилсэн Хөгжил” тусгайлсан сэтгүүлийг бий болгож байна.

Бид анхны дугаараараа Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын талаар тодорхой мэдээлэл өглөө. Бүсчилсэн хөгжил гэж юуг хэлээд байгаа, ямар стратеги төлөвлөгөөгөөр хэрэгжих юм, бүсүүд газарзүйн онцлог, ялгаагаар хэрхэн хөгжих вэ, ямар төсөл хөтөлбөрүүд, ямар бүтээн байгуулалтууд өрнөж, хэрхэн хөрөнгө оруулалт татаж ажиллах зэрэг агуулгыг багтаалаа.

Бид шинэ сэтгүүлээрээ дамжуулан Улаанбаатар хот, 21 аймаг, 330 суманд хүрч, шинэ бодлогын хэрэгжилт, үр дүнгийн талаар мэдээ мэдээлэл бэлтгэж, бодлого тодорхойлогчид, хувийн хэвшил, олон улсын байгууллага, хөрөнгө оруулагчид, орон нутгийн уншигчдад хүргэх болно. Энэ чиглэлээр бид Шинэ бодлогын хэрэгжилтийг хангаж ажиллах Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэнтэй хамтран ажиллана.

Төр, засгийн зүгээс Бүсчилсэн хөгжлийн талаар нэгдсэн нэг ойлголт мэдээлэлтэй байж энэхүү бодлого амжилттай хэрэгжинэ гэдэг дээр бүгд санал нийлж, бүсчилсэн хөгжлийн форум, зөвлөгөөнүүдийг бүс бүрээр хийж олон нийтэд үнэн зөв мэдээлэл өгөхийг зорьж байна. Энэ хүрээнд бид ч нэгдэж, уншигч та бүхэнтэйгээ мэндчилж байна.

Бүсчилсэн хөгжлийн бодлого үр дүнд хүрвэл улс богино хугацаанд хөгжинө. Улаанбаатар хотын төвлөрөл задарснаар орон нутаг хөгжиж, улмаар ард иргэд ийш тийш нүүдэллэхгүйгээр төрсөн нутагтаа сэтгэл хангалуун сайхан амьдрах нөхцөл бүрдэх юм.

Шинэ сэтгүүлийн анхны дугаарын уншигч та бүхэнд эрүүл энх, амжилт бүтээлийн дээдийг хүсэн ерөөе.

Бүсчилсэн Хөгжил сэтгүүлийн редакц

БҮСИЙН ХӨГЖИЛ УЛСЫН ХӨГЖЛИЙГ ХӨТӨЛНӨ



Хойд бүсийн тэргүүлэх чиглэлийг Байгалийн аялал жуулчлалын төрөлжсөн бүс бөгөөд аж үйлдвэрийн дэд бүс байхаар Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тусгасан.

Энэхүү баримт бичигт бүс, орон нутгийн хөгжлийн ялгааг багасгаж, эдийн засгийн хувьд төрөлжүүлж, хүн амын шилжилт хөдөлгөөнийг тэнцвэржүүлэх замаар орон нутгийн хөгжлийн үзүүлэлтийг 20 хувиар нэмэгдүүлэх зорилтыг тавив.

Зүг чиг зөв бол хүрэх газар дөт гэж үгтэй. Монгол Улсыг 2026-2030 он хөгжүүлэх Үндсэн чиглэлийг УИХ баталснаар хөгжлийн зүг чиг тодорхой болж чадлаа. Гагцхүү хөгжлийн баримт бичгээ хэрэгжүүлж, үр дүнд хүрэх нь чухал юм.

“Шинэ итгэл-Эрс шинэтгэл”-ийг гол зорилгоо болгосон Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 8 бодлогын зорилтын нэг нь “Бүсийн хөгжил” юм. Бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлснээр Монгол Улс хөгжлийн цэгцрэх хөдөлгөөн өрнөж байна.

Бид төвлөрлийг сааруулах ёстой. Улсын төсөв зөвхөн үндэсний хэмжээний мега төслүүдээ санхүүжүүлдэг болно. Харин тухайн орон нутгийн хөгжлийн асуудлыг орон нутаг өөрөө шийддэг, төсвийн бие даасан байдлыг нь нэмэгдүүлсэн, мөнгөний эрх мэдлийг нь шилжүүлсэн жинхэнэ реформыг бид хийнэ.

Хойд бүсийн хэмжээнд хөдөө аж ахуйн гаралтай гол түүхий эд болох мах 82.8 мян. тн, сүү 26.0 мян.тн, ноос 4.5 мян.тн, ноолуур 1.1 мян.тн, арьс шир 2.8 сая ширхгийг тус тус бэлтгэн зах зээлд нийлүүлсэн байна. Цаашид хөдөө аж ахуйн салбарт судалгаанд суурилсан шинжлэх ухааны оролцоотой үйлдвэрлэлийг хөгжүүлэх хэрэгтэй. Монгол Улс үйлдвэрлэлийг хөгжүүлэх хамгийн давуу тал нь органик хүнс. Хойд бүсийн хөгжлийг эрчимжүүлэхийн тулд нэн

тэргүүнд хэрэгжүүлэх төслүүдийн саналыг салбарын яамд, орон нутгаас авч, саналыг нэгтгэн, эрэмбэлж дараах 5 мега төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Үүнд:

- *Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр барих (Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант сум);*
- *Мөрөн нисэх буудлыг 4С ангиллын нисэх буудал болгон өргөтгөж, олон улсын нислэг хүлээн авах боломжийг судална. (Хөвсгөл);*
- *Эгийн голын усан цахилгаан станц барина. (Булган аймаг, Хутаг-Өндөр сум);*
- *Бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан аймгуудын мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг төрөлжүүлж, бүсүүдэд дадлага, үйлдвэрлэлийн бааз байгуулна. (Хөвсгөл, Булган аймаг);*
- *ШУТИС-ийн Геологи, уул уурхайн сургууль болон Мэдээлэл холбооны технологийн сургуулийг Орхон аймагт шилжүүлэх. (Орхон аймаг)*

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд 7 бүсийн тогтолцоотой болсны дагуу бүс бүрд бүсийн зөвлөлийг байгуулсан юм. Бүсийн зөвлөлийн даргын бүрэн эрхийг тус бүсэд багтах аймгийн Засаг дарга нар ээлжлэн хэрэгжүүлнэ. Мөн Бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдааныг тухайн бүсэд хамаарах аймгуудад жил бүр ээлжлэн зохион байгуулахаар төлөвлөж байна.

Бүс нутгийн хөгжил улс орны хөгжлийг тэргүүлнэ. Бүсийн хөгжилд иргэн бүрийн оролцоо, хандлага, хичээл зүтгэл хамгаас чухал.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР**

МОНГОЛ УЛСЫН БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН РЕФОРМЫГ ТАВАН ШИНЭТГЭЛИЙН ХҮРЭЭНД ЭХЛҮҮЛНЭ



Эрхэм хүндэт уншигчид аа!

Монгол Улсын Засгийн газраас “Шинэ итгэл, эрс шинэтгэл” цогц реформыг дэвшүүлсэн бөгөөд Бүсийн хөгжлийн реформ үүнд багтаж байгаа юм.

Засгийн газрын дэвшүүлсэн цогц реформыг хэрэгжүүлэх зорилгоор бүсчилсэн хөгжлийн бодлогыг бодит ажил, тодорхой үр дүнд чиглүүлэн олон ажил санаачлан хэрэгжүүлж байна. УИХ-ын 2024 онд баталсан “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал” нь бүс бүрийн давуу талд тулгуурласан тэнцвэртэй, тогтвортой хөгжлийн тогтолцоонд шилжүүлэх суурь баримт бичиг болсон.

Энэхүү бодлогын хэрэгжилтийг хангах хүрээнд “Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулан ажиллаж байгаа бөгөөд бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохион байгуулалт, бүсийн зөвлөл, түүний бүрэлдэхүүнийг оновчтой тодорхойлж, жил бүрийн Улсын төсвийг бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих тогтолцоонд шилжүүлэх зохицуулалтуудыг бий болгох чиглэлээр ажиллаж байна.

Түүнчлэн “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн “Бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөр”-ийг боловсруулах ажлыг эхлүүлээ. Энэ хүрээнд аймаг, орон нутгийн байгалийн нөхцөл нөөц, онцлог, давуу талд тулгуурлан эдийн засгийн чиг үүргийг тодорхойлж, түүнд чиглэгдсэн төсөл, арга хэмжээг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд үр өгөөжтэй хамтран хэрэгжүүлж, бүсийн нийгэм, эдийн засгийн өсөлт хангагдан харьцангуй тэнцвэртэйгээр хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

Тус бодлогын баримт бичигтэй уялдуулан аймаг, орон нутаг дунд, богино хугацааны хөгжлийн бодлогоо боловсруулж, улсын,

бүсийн, орон нутгийн түвшинд бодлогын уялдаа хангагдах юм. Тухайлбал, үндэсний үзэл баримтлал, бүсийн зорилтот хөтөлбөр, орон нутгийн бодлого, төлөвлөлт гэсэн гурван түвшний бодлого цогц, уялдаатай тодорхойлогдож улс, орон нэг зүгт харж хөгжих нөхцөл бүрэлдлээ. Ингэснээр бүсийн хөгжлийг дэмжих томоохон ач холбогдолтой бүтээн байгуулалтын төслүүд гурван түвшний бодлогын баримт бичгүүдэд тусгагдан хэрэгжих юм.

Бүсчилсэн хөгжлийн бодлогын хамгийн гол зорилго чиглэл бол аж ахуйн нэгж, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг борлуулалтаар нь дэмжих, дотоод гадаадын зах зээлд холбон бизнес, хөрөнгө оруулалтын шинэ боломжийг бий болгож, бүсүүдийг бие даан хөгжих эдийн засгийн чадавхтай болгоход чиглэнэ. Ингэснээр хот, хөдөөгийн ялгаа бодитоор багасаж, иргэдийн амьдралын чанар сайжирна.

Энэхүү бодлого нь “Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”, Засгийн газрын 2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй бүрэн уялдсан үндэсний хэмжээний бодлого юм. Бүсчилсэн хөгжил бол зөвхөн төрийн ажил бус, хувийн хэвшил, орон нутаг, иргэдийн хамтын оролцоонд тулгуурлан амжилтад хүрэх стратеги билээ.

Бид хамтдаа бүсчилсэн хөгжлийн шинэ үеийг эхлүүлж, Монгол Улсын тогтвортой, тэнцвэртэй өсөлтийн бат бөх суурийг тавина гэдэгт итгэлтэй байна.

Уншигч Та бүхэнд амжилт, бүтээлийн дээдийг хүсэн ерөөе.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН,
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН,
МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД
ХАССУУРИЙН ГАНХУЯГ

МОНГОЛ УЛСЫН БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН



И.Х.ОВДИЕНКОГ-ИЙН
БОЛОВСРУУЛСАН
ЭДИЙН ЗАСГИЙН
МУЖЛАЛЫН СХЕМ



ОЛНОО ӨРГӨГДСӨН
МОНГОЛ УЛСЫН ҮЕИЙН
ЗАСАГ ЗАХИРГАА НУТАГ
ДЭВСГЭРИЙН ХУВААРЬ



Д.ДАНДАРБААТАР,
Д.САЙН-ЭР НАРЫН
ДЭВШҮҮЛСЭН ЭДИЙН
ЗАСГИЙН БҮСЧЛЭЛ


1919

1967

1997


1961

П.А.АЛАМПИЕВ, Ч.СЭРЭЭТЭР
НАРЫН БОЛОВСРУУЛСАН ЭДИЙН
ЗАСГИЙН МУЖЛАЛЫН СХЕМ



1997

М.ЭНХСАЙХАНЫ
ДЭВШҮҮЛСЭН ЭДИЙН
ЗАСГИЙН БҮСЧЛЭЛ



Б.ГУНГААДАШИЙН
БОЛОВСРУУЛСАН
“ЭДИЙН ЗАСГИЙН
МУЖ”-ИЙН ЗУРАГЛАЛ



СУДЛАГДСАН БАЙДАЛ



МОНГОЛ УЛСЫН БҮСЧИЛСЭН
ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН
ХҮРЭЭНД БАТЛАГДСАН “ЭДИЙН
ЗАСГИЙН МУЖ”

2001

Ц.СҮХБААТАРЫН ДЭВШҮҮЛСЭН
ЭДИЙН ЗАСГИЙН БҮСЧЛЭЛИЙН
ЗАГВАР



2018

2011

АРДЧИЛСАН НАМ “МОНГОЛ
ХҮН-2020” ХӨТӨЛБӨРИЙН
ХҮРЭЭНД ДЭВШҮҮЛСЭН ЭДИЙН
ЗАСГИЙН БҮСЧЛЭЛ




2020



Р.РИНЧИНБАЗАР,
Д.ЭРДЭНЭБАЯР НАРЫН
ДЭВШҮҮЛСЭН ЭДИЙН ЗАСГИЙН
БҮСЧЛЭЛИЙН ЗАГВАР

Онцлох нийтлэл

МОНГОЛЧУУД БИД ИРЭЭДҮЙН ХӨГЖЛИЙН ЧИГ
ЛУУЖИНТАЙ БОЛЖ, НЭГ ЗҮГТ ХАРЖ ХӨГЖИХ
ХӨГЖЛИЙН ШИНЭ ЗАГВАРТАЙ БОЛЛОО



БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО ХӨГЖЛИЙН ШИНЭ ЗАГВАР

Дэлхийн улс орнуудын хөгжлийн онол өөрчлөлт орж, бүсчилсэн хөгжлийн загварыг чухалчлан үзэх болжээ. Учир нь улс орон бүр өөр өөрийн газар нутгийн онцлог түүх, соёл, үнэт зүйлсийн өвтэй. Сэтгэлгээний хүрээлэл ч өөр. Тийм учраас нэг загварт цутгасан бодлогоор бус улс орнууд өөрийн онцлогоо гаргаж, түүндээ тулгуурлан хөгжлийн бодлогоо явуулах ёстой гэсэн онол илүү жин дарах болжээ. Өөрөөр хэлбэл, газар нутаг, хүн амын байршил, баялгийн нөөцдөө үндэслэн бүсчилсэн байдлаар хөгжих нь хамгийн зөв бодлого юм гэж үзэх болсон байна.

Монгол Улсын хувьд энэхүү хөгжлийн онол дэлхий дахинаа хүчтэй дэлгэрсэн үеэс 20 жилийн дараа буюу 2011 онд бүсчилсэн хөгжлийн бодлогыг баталсан. Гэхдээ дорвитой хэрэгжээгүй. Харин 23 жилийн дараа буюу 2024 онд Монгол Улс бүсчлэн хөгжихөөр баттай шийдэж, УИХ “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ыг баталсан. Монгол Улсын ирээдүйн хөгжил

бүсчилсэн байдлаар явна гэдэгт улс төрийн намууд, эдийн засагч, бизнес эрхлэгчид, эрдэмтэд бүгд санал нэгдэж, хөгжлийн чиглэлээ тодорхойллоо. Одоо монголчууд бид бодитой хөгжлийн чиг, луужинтай болж, нэг зүгт харж явах бодлогын баримт бичигтэй болсон гэсэн үг.

Сүүлийн 23 жилд бүсчилсэн хөгжлийн бодлогын олон баримт бичигт өөрчлөлт орж, нэмж хасч, нэрийг өөрчлөх зэрэг олон асуудал өрнөсөөр ирсэн. Нэг нам гарч ирж, нэрийг өөрчлөөд, дөрвөн жилийн дараа өөр нэг нам дахин өөрчлөх гэх мэт хөгжлийн загварын хувилбаруудыг гаргаж ирж туршиж, хэрэгжүүлж, алдаж оносоор ирсэн гэж хэлэхэд хилсдэхгүй. Харин өнөөдөр Монголын хөгжлийн шинэ загвар бол Бүсчилсэн хөгжил гэдгийг баталгаажуулж, Үндсэн хуульдаа өөрчлөлт оруулж, парламентын сонгуулийг бүсчилсэн хэлбэрээр явуулсан. Үр дүнд нь парламентад суудалтай гол гурван намын хамтарсан Засгийн газар байгуулагдаж, төсөв мөнгө, үйл ажиллагааны хөтөлбөрөө бүсчилсэн

хөгжлийн дагуу зураглаж байна. Энэ бол улс төрийн хувьд ч, эдийн засаг, бизнесийн хувьд ч маш том дэвшил. Тийм учраас “Бүсчилсэн хөгжлийн бодлого бол Монгол Улсын ирээдүйн хөгжлийн хамгийн зөв бөгөөд цорын ганц шийдэл” гэж Шадар сайд С.Амарсайхан хэлж байна.

Яагаад бүсчлэн хөгжье гэж?

Хүн амын өсөлт Улаанбаатар хотод 2.6, орон нутагт 1.5 хувь, ядуурал нийслэлд 21.6, орон нутагт 30 хувь байна.

Худалдаа үйлчилгээ нийслэлд 84 хувь, хөдөөд 6 хувь, их дээд сургууль хотод 96, хөдөөд 4 хувь. Улаанбаатар хотын нийт автозамын 78 хувь түгжрэлтэй, гол замын даац гурав дахин хэтэрсэн, РМ 2.5 тоосонцрын бохирдол аюулгүйн түвшнээс 27 дахин хэтэрсэн.

Эдгээр тоон үзүүлэлт манай улсын хөгжлийн бодит байдлыг тод харуулна. Мөн Улаанбаатар хотын хөгжлийн, амьдралын даац хэтэрснийг нотолж байна.



ЯДУУРАЛ НИЙСЛЭЛД 21.6, ОРОН НУТАГТ 30 ХУВЬ, ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУВЬД НИЙСЛЭЛД 84, ХӨДӨӨД 6 ХУВЬ, ИХ ДЭЭД СУРГУУЛЬ ХОТОД 96, ХӨДӨӨД 4 ХУВЬ БАЙНА.

БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО ЯАГААД ЧУХАЛ ВЭ?

	Хүн амын өсөлт /хувиар/	Ядуурал /хувиар/	Өрхийн орлого /₮/	Хүний хөгжлийн индекс /оноо/	PISA үнэлгээ /зөрүү/
ОРОН НУТАГТ	1.5	30%	1.9 Сая ₮	0.76	1.5 ЖИЛ хоцрогдол
УЛААНБААТАРТ	2.6%	21.6%	2.6 Сая ₮	0.83	

НИЙТ АВТО
ЗАМЫН

**78%**
ТҮГЖРЭЛТЭЙ

ГОЛ ЗАМЫН
ДААЦ

**3**
ДАХИН ХЭТЭРСЭН

PM 2.5 ТООСОНЦРЫН
БОХИРДОЛ

**27**
ДАХИН ХЭТЭРСЭН


ГАМШГИЙН УЛМААС
УЧИРСАН ХОХИРОЛ

**47.1**
ТЭРБУМ ТӨГРӨГ

Улаанбаатар хотын PM2.5
тоосонцрын бохирдол аюулгүйн
түвшнээс 27 дахин хэтэрсэн



Монгол Улсыг нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд Хангайн, Баруун, Хойд, Төвийн, Зүүн, Говийн, Улаанбаатарын гэсэн долоон эдийн засгийн бүс болгон хөгжүүлэхээр тогтсон бөгөөд төлөвлөлт, хэрэгжилт, бүс нутгийн хөгжлийг дэмжих дэмжлэгийн хэлбэр, механизмыг бүрдүүлэх бодлого, эрх зүйн орчин бүрдэж, бүс орон нутгийн хөгжлийн түвшний ялгаа багасаж, эдийн засгийн өсөлт нэмэгдэх юм.



Хөдөө орон нутагт хүн ам цөөрч, хөгжил 1.5 жилээр хоцрогдсон гэсэн тоог онцолъё.

Тиймээс бүсчилсэн хөгжлийн онолын чухал хэсэг болох орон зайн төлөвлөлтөд түлхүү анхаарахаас өөр аргагүйд хүрсэн тухай судлаачид тэмдэглэж байна.

“Орон зайн төлөвлөлтийн олон аргын нэг нь бидний одоо хэрэгжүүлэхээр зорьж буй бүс нутгийн, бүсчилсэн хөгжил, бүсчилсэн төлөвлөлт юм. Орон зайн төлөвлөлт нь тодорхой орон зайн эсвэл аймаг, бүсийн тодорхой нөөцийг хамтран зөв зохистой ашиглах замаар хөгжлийг түргэсгэх, хамгийн гол нь хөгжлийн үр ашгийг олон нийтэд тэнцвэртэйгээр хүргэх юм” гэж МУИС-ийн багш, доктор профессор В.Батцэнгэл яриув.


Бүсчилсэн хөгжлийн үндэсний форумд хэлсэн үгэндээ Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ “Хандлагаа өөрчилъё. Бүх түвшинд хандлага, сэтгэлгээгээ өөрчилж чадвал богино хугацаанд хөгжих боломж бүрдэнэ” гэсэн юм.

Монголчууд бид эрт дээр үеэсээ орон зайн маш өргөн хүрээний сэтгэлгээтэй, дэлхийг өөрийнхөө эх орон, гэрээ гэж үздэг байсан. Гэтэл сүүлийн жилүүдэд бидний сэтгэлгээ харьцангуй явцуурч, зөвхөн аймаг, сум, гол усны хэмжээнд очсон. Энэ явцуу сэтгэлгээнээс гарах нэг арга бол орон зайн сэтгэлгээг өргөн хүрээнд ойлгох явдал гэдгийг В.Батцэнгэл профессор тодотгосон билээ.

Бид одоо хандлага, оюун сэтгэлгээндээ өөрчлөлт хийх

ёстой болж байна. Бид дэлхийн талыг эзэлж, оюун сэтгэлгээний хувьд дэлхийг багтааж байсан улс түмний үр сад. Мөн бүсчилсэн хөгжлийн бодлогыг тэртээ XIII зуунд хэрэгжүүлэн газар нутгаа Ази, Европ, Дундад Ази хүртэл тэлсэн түүх бол монголчуудынх. Тиймээс огт шинэ биш бүсчлэн хөгжих бодлогыг зөв зүйтэй хэрэгжүүлж, улс орноо богино хугацаанд хөгжүүлэх нь зүйтэй байна. Үүний тулд улсаараа, бүсээрээ, аймгаараа, сум, багаараа талцах асуудлыг зогсоож, шинэ хандлага, шинэ сэтгэлгээгээр нэгдэн нийлж хөгжих нь хамгийн чухал боллоо.

Шинэ хөгжлийн загварын тухай ойлголтоо ч бид нэгтгэх ёстой. Нэгдмэл нэг ойлголт, мэдээлэлтэй байж бодлого шат шатандаа асуудалгүй хэрэгжих нөхцөл



бүрдэх юм. Энэ хүрээнд Бүсчилсэн хөгжлийн үндэсний форум болон бүсүүдэд уг зөвлөгөөнийг зохион байгуулаад байна.

Бүсчилсэн хөгжлийн бодлогоор Монгол Улсыг 7 бүс нутгаар авч үзсэн. Бүс нутгуудын газар зүйн онцлог ялгаагаар нь Баруун, Зүүн, Хангай, Төв, Говь, Хойд, Улаанбаатарын бүс гэж хөгжүүлэхээр тусгасан. Харин 330 сумын дунд 91 өсөлтийн сум, төвийг бий болгоно.

Бүс нутгийн онцлог давуу талуудыг нээн илрүүлж хөгжүүлж, хоршиж, төрөлжүүлж, дагнана. Тэнцвэртэй оролцоо буюу УИХ, Засгийн газар, хувийн хэвшил, орон нутаг, эрдэмтэн судлаачдын оролцоог хангаж ажиллана. Бүсчилсэн хөгжлийн гол зарчим нь хувийн хэвшлийг дэмжиж, гадаад,

дотоодын хөрөнгө оруулалтыг татахад түлхүү анхаарах талаар төрийн түшээд онцолж байгаа.

“Бид хөгжлийн онолын үүднээс зөв зам дээрээ гараад ирлээ” гэж УИХ-ын гишүүн Д.Бум-Очир хэлсэн юм.

Улаанбаатар гэсэн ганцхан чиглэлтэй таталцлыг багасгаж, тараан байршуулах, аймаг сумдыг газар зүйн байршил, соёлын онцлогоор нь хоршин хөгжүүлснээр орон нутгийн ард иргэдийн нийслэл рүү нүүх сэтгэлгээнд өөрчлөлт хийж, төрж өссөн нутагтаа ажиллаж амьдрах боломжийг нээж өгөх нь бүсчилсэн хөгжлийн хамгийн гол зорилго билээ.


Монголчууд бид өнгөрсөн 30 жилд зөвхөн нийслэл рүү чиглэх урсгалаар явсан. Жилдээ 60 мянган

хүн хотод ирж суурьшсан судалгааг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр гаргажээ. Ингээд бид нийслэлдээ 1.6 саяулаа болж, дөрвөн уулын дундаа ачааллаа дийлэхгүй газарт бөөгнөрөн амьдарч, олон асуудлыг үүсгэж буйгаа бүгд мэднэ. Утаа, түгжрэл, хөрсний бохирдол, өвчлөл, эрчим хүчний дутагдал, боловсрол, эрүүл мэнд гэх мэт.


Тэгвэл одоо орон нутгийг хөгжүүлэхэд анхаарч, төр эрх зүйн бодлогоо Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалаар дамжуулан хэрэгжүүлнэ. Эргээд харахад, энэ нь Монгол Улсын хөгжлийн хамгийн зөв, хамгийн оновчтой бодлого мөн гэдгийг улстөрчид ч, эрдэмтэн судлаачид ч хүлээн зөвшөөрч байна.

Тоон мэдээлэл


ХҮН АМ /ЭЗЛЭХ ХУВИАР/




ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БҮЙ ААН ТОО



МАЛЫН ТОО /САЯ ТОЛГОЙ/



ДУНДАЖ ЦАЛИН /САЯ ₮/



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2023

12.27

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2023 ОНЫ 481 ДҮГЭЭР ТОГТООЛООР 2024 ОНЫГ “БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ЖИЛ” БОЛГОН ЗАРЛАВ.

2024

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН 2024 ОНЫ 11 ДҮГЭЭР ЗАХИРАМЖААР “БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ” ШИНЭЧЛЭХ, ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖИД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙГ БАЙГУУЛАВ.

01.16

МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЧУУЛГАН - БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨГӨӨНИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАВ.

02.01,02

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ 64 ДҮГЭЭР ТОГТООЛООР “МОНГОЛ УЛСЫН БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ”-ЫГ БАТЛАВ.

06.05

06.29

2024 ОНЫ УИХ-ЫН ЭЭЛЖИТ СОНГУУЛЬ АНХ УДАА БҮСЧИЛСЭН ТОЙРГООР ЗОХИОН БАЙГУУЛАГДАВ.

ЗАСГИЙН ГАЗРЫН 2024 ОНЫ 33 ДУГААР ТОГТООЛООР “БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН” -Г БАЙГУУЛАВ.

08.14

08.24

ЗАСГИЙН ГАЗРЫН 2024 ОНЫ 21 ДҮГЭЭР ТОГТООЛООР “БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ҮНДЭСНИЙ ХОРОО”-НЫ БҮРЭЛДЭХҮҮНИЙГ ШИНЭЧЛЭН БАТЛАВ.

ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН НЭГДҮГЭЭР БҮЛЭГТ “БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО”-ЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТУСГАВ.

08.27

10.08

БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ АНХДУГААР ХУРЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ.

“БҮСҮҮДИЙН ХӨГЖЛИЙН ҮНДЭСНИЙ ЧУУЛГАН”-ЫГ ШИНЭ СТАНДАРТ УРИАТАЙГААР ХОЛБОГДОХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДАЙ ХАМТРАН УЛААНБААТАР ХОТНОО ЗОХИОН БАЙГУУЛАВ.

10.26

11.28

“ТӨВИЙН БҮСИЙН ХӨГЖЛИЙН ҮНДЭСНИЙ ЧУУЛГАН”-ЫГ ШИНЭ СТАНДАРТ УРИАТАЙГААР ХОЛБОГДОХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДАЙ ХАМТРАН ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ДАРХАН ХОТНОО ЗОХИОН БАЙГУУЛАВ.

2025

ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРГӨТГӨСӨН ХУРАЛДААНААС БҮСИЙН ЗӨВЛӨЛҮҮДИЙГ БАЙГУУЛЖ, БҮСИЙН ЗӨВЛӨЛИЙН ӨРГӨТГӨСӨН ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ШИЙДВЭР ГАРГАВ.

01.14

02.03

БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ХУРАЛДААНААР БҮСИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ, ИДЭВХЖҮҮЛЭХ ХӨДӨЛГӨӨН ӨРНҮҮЛЭХЭЭР ШИЙДВЭРЛЭВ.

БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ДЭРГЭДЭХ ЭРДЭМТДИЙН ОРОН ТООНЫ БҮС ЗӨВЛӨЛ БАЙГУУЛАГДАВ.

03.14

04.14

ХАНГАЙН БҮСИЙН ЗӨВЛӨЛИЙН АНХДУГААР ХУРАЛДААН БОЛОВ.

ХОЙД БҮСИЙН ЗӨВЛӨЛИЙН АНХДУГААР ХУРАЛДААН БОЛОВ.

04.28

Онцлох ярилцлага

**МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД С.АМАРСАЙХАН:
БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛ БОЛ ШИНЭ
ЦАГИЙН СЭРГЭН МАНДАЛТЫН БОДИТОЙ
ХЭРЭГЖИХҮЙЦ БОДЛОГО ЮМ**



Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхантай Бүгд Найрамдах Узбекистан Улсын Самарканд-Ташкент чиглэлийн хурдны галт тэргэнд хийсэн ярилцлагыг хүргэж байна. Монгол-Узбекистаны Засгийн газар хоорондын комиссын анхдугаар хуралдаан хоёрдугаар сард тус улсын нийслэл Ташкент хотод болсон бөгөөд С.Амарсайхан сайд тус комиссын Монголын хэсгийн даргаар ажилладаг юм.

Харин Самарканд нь Узбекистан улсын түүх, соёлын гол төв төдийгүй монголчуудын өвөг дээдэс суурьшиж байсан хот гэдгээрээ онцлогтой. Иймээс бид ярилцлагаа Самаркандын түүхээс эхлүүлсэн юм.

Доголон Төмөр (Тамирлан) гэж алдаршсан Их хааны бунхан: Өвөг дээдсээрээ бахархахын сацуу асар их зүйл бодогддог

-Бид түүхэнд Доголон Төмөр (Тамирлан) гэж алдаршсан Их хааны бунханд цогцолборыг үзэж сонирхоод, одоо Ташкент руу буцаж байна. Танд ямар сэтгэгдэл төрснөө хуваалцахгүй юу?

-Монгол хэмээх энэ нэр, энэ түүх мянга мянган жилийн хатуу ширүүн нугачааг даван туулж, энэ цагийн бидний түүхийг ч Монгол хэмээх нэг дээвэр дор он цагийн судар бичээст тамгалсаар байгаа нь монголчуудын бахархал юм. Дэлхийн цөөнгүй улс орны түүх дурсгал, мөн бахархал нь болж өнөөг хүртэл хадгалагдан байгаа өвөг дээдсийнхээ түүхэн ул мөр, улбаа хэлхээг үзэж судлах бүрт асар их зүйл бодогддог. Та бүхэнд ч тийм л байдаг байх. Манай эх орны тусгаар тогтнол, үнэ цэн өвөг дээдсийн минь ямар их ур ухаан, сэтгэлийн хат, итгэл зүтгэлээр бидэнд өвлөгдөн ирсэн бэ гэдгийг сануулдаг, сэрээдэг, мэдрүүлдэг. Энэ түүхээрээ бид бахархаж, эрч

хүч авч, илүү хариуцлагажиж, бүр ихийг хийж бүтээх итгэл үнэмшил авч байх ёстой юм.

Дэлхийн талд Pax Mongolica буюу Монголын их амар амгалан хэмээх тодотголтой дэг журмыг тогтоож явсан өвөг дээдсийн үр сад бид өнөөдөр төөрөлдөж, биенээ үгүйсгэж, бусдын золиос болж болохгүй цаг үед амьдарч байна. Он цагийн уртад нүүдэлчин соёл иргэншлээ түүх болгон бичиж үлдээгээд зогсохгүй үргэлжлүүлэн өвлүүлж ирсэн ард түмний хойч үе гэдгээрээ бид дэлхийд ондоошин ялгардаг. Тиймээс дотооддоо илүү эв эетэй, хүндэтгэлтэй хандах уламжлалт ёс заншлаа хадгалж байж л бид Монгол хэмээх энэ улс үндэстнээ хэвээр хадгалж үлдэнэ. Мөн бусад улс үндэстэнд ч илүү их хүндэтгэлтэй, зарчимтай байх, аливаа асуудалд илүү ухаалаг, ул суурьтай хандах учиртай гэж би боддог.

Торгоны зам ба эртний “бүсчилсэн хөгжил”

-Монголын эзэнт гүрний хаад, ноёд энэ бүс нутгийг эзэлж,

улмаар худалдаа наймааны гол цэгээ болгож байсан түүхтэй. Өвөг дээдэс маань худалдаа наймаа хийх үүднээс зах зээлийг тэлж, “бүсчилсэн хөгжил”-ийн бодлогыг XIII зуунаас хэрэгжүүлж иржээ. Олон зуун жилийн дараа Монгол Улсын Шадар сайдаар ахлуулсан баг Узбекистан улсад мөн зах зээлээ тэлэх, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэхээр ирээд байна. Энэхүү ажлын айлчлалын гол ач холбогдлын талаар ярина уу?

-Бүсчилсэн хөгжил гэдэг шинэ ойлголт огт биш. Тод жишээ нь Торгоны зам. Эрт цагт бүс нутгуудын худалдаа, наймааны гол зангилаа нь Торгоны зам байсан шүү дээ. 1200-гаад онд Их эзэн Чингис хааны хөвгүүд Зүчи, Цагаадай нар Хорезмын улсыг дайлаар мордож, энд нутагшин суурьшиж, ажил амьдралаа үргэлжлүүлсэн байдаг. Тухайн үед Хорезм бол Төв Ази, Дундад Азийн гол төв, Торгоны замын хамгийн чухал зангилаа байсан түүхтэй.

Түүхийн улбаа хэлхээтэй манай хоёр улс дипломат харилцаа тогтоогоод 33 жил болж байна. Монгол Улсын Ерөнхийлөгч



Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан Доголон Төмөр хааны бунхны өмнө. Узбекистан. Самарканд хот. 2025 оны хоёрдугаар сар

У.Хүрэлсүх өнгөрсөн зургаадугаар сард Узбекистан улсад анх удаа төрийн айлчлал хийсэн. Тэгвэл энэ удаагийн Засгийн газар хоорондын комиссын анхны хуралдаанаар хил орчмын хамтын ажиллагааг өргөжүүлэх, аялал жуулчлалыг хөгжүүлэх, худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, зах зээлийг тэлэх зэрэг томоохон санаачилга, шийдвэр гаргалаа. Бизнесийн салбарт ялангуяа “хил орчмын худалдаа арилжааг бүс нутагтайгаа уялдуулах” ажлуудад илүү ач холбогдол өгч байна.

Засгийн газар хоорондын комиссын хуралдаанаас доорх онцлох шийдвэрүүдийг гаргалаа.

Нэгдүгээрт, Улаанбаатар–Ташкентын хооронд шууд нислэгийг энэ оны хоёрдугаар улирлаас эхлүүлэхээр тохиролцсон. Үүгээр аялал жуулчлалын салбарт асар том шинэ боломж нээгдэнэ.

Хоёрдугаарт, Авто тээврийн шинэ маршрутыг нээлээ. ОХУ-аар дамждаг байснаас 1000 км-ээр дөт, Узбекистан–Киргизстан–Үрүмчи–Ховд–Булган боомт–Улаанбаатар чиглэлийн замыг албан ёсоор нээсэн. Энэ нь тээврийн зардал, хугацааг эрс багасгах ач холбогдолтой.

Гуравдугаарт, Хөдөө аж ахуйн салбарын бодит хамтын ажиллагаа ажил хэрэг болж эхэллээ. Узбекистан манай улсаас 100 мянган хонь авахаар гэрээ байгуулсан бөгөөд 2024 онд 7000 хонийг онгоцоор тээвэрлэсэн. Монгол хонь маань эхнээсээ төллөж эхэлсэн сайхан мэдээ сонслоо. Цаашид узбек үүлдрийн хуц Монголдоо авчран шинэ үүлдэр гаргах, хонин сүргийн бүтцийг сайжруулах зэрэг ажил хийнэ.

Дөрөвдүгээрт, Худалдаа, эдийн засгийн төвүүдийг нээнэ. Энэ зургаадугаар сардаа багтаад Улаанбаатар, Ташкент хотуудад худалдаа, эдийн засгийн төвийг харилцан нээхээр боллоо. Монголын талаас 50 гаруй бизнес эрхлэгч ирж, Монгол–Узбекистаны

бизнес форумд оролцсон. Манай 10 гаруй компани энэ улсын зах зээлд аль хэдийн үйл ажиллагаагаа эхлүүлжээ. Тухайлбал, “Монгол Базальт” үйлдвэрээ Ташкент хотод барьж байна, “Таванбогд Групп” НУРА төв салбараа нээсэн, “Voyage Mongolia” төлөөлөгчийн газраа нээж усаа борлуулаад эхэлсэн гэх мэт олон ажил амжилттай урагшилж байна.

Манайх хүн ам цөөн, дотоодын зах зээл жижиг улс. Гэхдээ байгалийн асар их нөөц баялагтай. Тиймээс бидэнд гадагшаа чиглэсэн шинэ зах зээл нээх нь хамгийн чухал. Узбекистан бол 40 орчим сая хүн амтай, хүн ам нь жилд дунджаар 1-3 саяар нэмэгдэж буй, далайд гарцгүй улс. Амьдралын хэв маяг, зан араншин монголчуудтай төстэй учир ойлголцоход амар, зах зээл нь ч том улс юм. Энэ боломжийг бизнес эрхлэгчид маань өргөнөөр ашиглаасай гэж хүсэж байна.

Зах зээлээ тэлэх нь Бүсчилсэн хөгжлийн бодлогын нэг зорилго

–Бүсчилсэн хөгжлийн бодлогын гол зорилго дотооддоо бус гадагшаа зах зээлээ өргөжүүлэх, экспортыг нэмэгдүүлэхэд чиглэж байна гэж ойлгож болох уу?

–Тийм ээ. Нэг аймаг, нэг суманд асуудлаа төвлөрүүлж ярьсаар байвал урагшлахгүй нь тодорхой болсон. Бид эдийн засгаа өсгөж, үйлдвэрлэлээ нэмэгдүүлсэн ч дотооддоо эрэлт бага учраас зайлшгүй гадагшаа гарах шаардлага үүсэж байна. Үүний тулд эхлээд хоёр хөрштэйгээ хил орчмын хамтын ажиллагааг өргөжүүлж, улмаар хоёрдогч, гуравдагч улс орны зах зээл буюу Узбекистан, Киргизстан, Казахстан, Евроазийн эдийн засгийн холбооны гишүүн орнууд, цаашлаад дэлхийн бусад зах зээл рүү гарах үүд хаалгыг нээх шаардлагатай.

Засгийн газраас 21 аймаг, 330 сумыг долоон бүсэд хувааж, аж үйлдвэр, аялал жуулчлал, уламжлалт болон эрчимжсэн мал аж ахуй, сэргээгдэх эрчим хүч зэрэг чиглэлээр төрөлжүүлэн хөгжүүлэхээр ажиллаж байна. Нийт 91 хөгжлийн төв байгуулах шийдвэр гарсан. Энэ бүхэн дотооддоо үйлдвэрлэл, үйлчилгээг эдийн засгийн тусгай бүсүүд, үйлдвэр технологийн паркаар дамжуулан хөгжүүлэх, хүний хөгжлийг чөлөөтэй дэмжихийн зэрэгцээ гадаад орчинд гарц нээх, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх зорилготой цогц бодлого юм.

Бид дотооддоо хүний хөгжил рүү чиглэсэн, бүсүүдийн хүн амын бүтэц, амьдралын чанар, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн дэд бүтцийг сайжруулах ёстой. Гадаад талдаа хил орчмын болон олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлж, худалдааны гол гарцыг нэмэгдүүлэх хэрэгтэй. Улаанбаатар дангаараа Монгол Улс биш шүү дээ. Тэгэхээр бусад бүсдээ гамшигт тэсвэртэй, чанартай, найдвартай дэд бүтцийг бий болгож, томоохон мега төслүүдээ хэрэгжүүлэх нь чухал. Зөв төсөл, зөв хөрөнгө оруулалт, төрийн зүгээс таатай орчныг бүрдүүлэх зэргээр системтэй дэмжээд өгвөл бизнес эрхлэгчид бүс нутагт очно, улмаар өрсөлдөөнд орж, боломж чадвараа нэмэгдүүлнэ.

Хувийн хэвшил, хөрөнгө оруулагчид бол улс орны хөдөлгөгч хүч

Шуудхан хэлэхэд хувийн хэвшил, гадаад дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжихгүйгээр Бүсчилсэн хөгжил урагшлахгүй. Бизнес эрхлэх, ашиг орлогын боломжгүй газар ямар ч компани хөрөнгө оруулахгүй. Тиймээс бид татварын уян хатан бодлого, хөрөнгө оруулалтын тогтвортой орчин бүрдүүлэхээр



Ард иргэдийн оролцоо, оюун сэтгэлгээний шинэчлэл

- “Манай өвөг дээдэс оюун сэтгэхүйдээ дэлхийг багтааж явсан, харин бид их жижигхэн сэтгэлгээтэй болжээ” гэж манай эрдэмтэд хэлсэн. Та бүсчилсэн хөгжил бол газарзүйн байршлаас гадна ард иргэдийн оюун сэтгэхүйг тэлэх, задлах бодлого гэж үзэж байна уу?

-Өнгөрсөн 30 жил “тэлэх бус хумих” сэтгэлгээгээр явснаар нийслэлд хүн ам бөөгнөрөх, хот төлөвлөлт алдагдах, утаа, түгжрэл гэх мэт сөрөг үр дагаварт хүргэсэн. Хүмүүсийн сэтгэлгээ ч өдөр тутмын ахуйн асуудалдаа л бухимдаж, томыг харж, өргөнөөр сэтгэх бололцоогүй болж ирсэн. Тэгвэл бүсчилсэн хөгжлөөр дамжуулан иргэдийн оюун санааг тэлж, бүтээлч сэтгэлгээг дээшлүүлнэ гэж харж байна.

Бидний өвөг дээдэс үнэхээр дэлхийн түвшний дипломат бодлого баримталж, олон улсыг холбосон худалдаа наймааг сэдэж, өөрсдийнхөө элч төлөөлөгчдийг илгээж байжээ. Чингис хаан Хорезм руу өөрийн гол элчийг 600 хүний хамт худалдаа наймаа, зах зээлийг тэлэх зорилготой явуулсан байдаг. 600 хүний бүрэлдэхүүнтэй баг гэдэг бол тухайн үедээ маш том үйл явдал. Харин Хорезмын хаад ноёд элч төлөөлөгч нарыг нь устгаснаас болж Чингис хаан дайлаар мордсон гэдэг түүх бий. Гэлээ ч өвөг дээдсийн маань дайлаар мордох эцсийн зорилго нь дэлхийд эв найрамдал, амар амгаланг тогтоох явдал байсан билээ.

-Улстөрчид, бизнесийнхэн, олон улсын байгууллагууд Бүсчилсэн хөгжлийн бодлогыг ойлгож дэмжиж байна. Харин ард иргэдийн түвшинд ойлголт ямар байна вэ?

-Ард иргэдийн оролцоо хамгийн чухал. Уг бодлогын хөдөлгөгч хүч нь иргэд, аж

ажиллаж байна. Монгол Улсын Ерөнхий сайдаар ахлуулсан Эдийн засгийн хөгжлийн зөвлөл байгуулагдан татвар, хөрөнгө оруулалт, нийгмийн даатгалын реформ хийхээр ажиллаж байна. Жишээлбэл, тодорхой тооноос доошгүй ажлын байр бий болгож, хөрөнгө оруулсан бол хөрөнгө оруулалтын хэмжээнээс шалтгаалан татвараас чөлөөлөх, давхар татварыг багасгах зэрэг уян хатан зохицуулалт бий болгоно. Бизнес эрхлэгчдэд ийм ашигтай нөхцөл олгосноор бүсчилсэн хөгжил бодит ажил болж урагшилна.

2024 оны зургаадугаар сард УИХ Бүсчилсэн хөгжлийн бодлогын үзэл баримтлалыг шинэчлэн баталсан. Удахгүй Удирдлага зохицуулалтын тухай хуулийг шинэчилнэ. 2025 оны төсөвт бүсчилсэн хөгжилд чиглэсэн томоохон төсөл, ТЭЗҮ боловсруулах ажлуудын зардлыг суулгасан нь манай төсвийн бодлогын түүхэнд анхны том алхам боллоо.

Нийт 91 хөгжлийн төвийг байгуулах ажлыг бодит болгохын тулд Засгийн газар ТЭЗҮ, зураг төслийг үнэ төлбөргүй хийж өгч байна. Энэ нь хувийн хэвшлийнхэнд томоохон дэмжлэг болно.

Бүсийн хөгжлийн зөвлөлүүдийг байгуулна. Тус зөвлөлийн гишүүд болох тухайн бүс нутгийн аймгийн удирдлагууд, УИХ-ын гишүүд, бизнес эрхлэгчид, хөрөнгө оруулагчид хамтран бүсийн бодлого, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг эрэмбэлж хэрэгжүүлэх бодлого механизмыг бий болгох юм.

Бүсчилсэн хөгжлийн асуудлыг энэ удаа цогцоор нь шийдсэн. Төрийн түвшинд эсэргүүцэл багатай, олонх нь дэмжиж байна. Өмнө нь нэг аймаг, нэг сум гэж ярьдаг байлаа. Харин одоо УИХ-ын гишүүд хүртэл “бүсчлэлээрээ” хамтарч асуудлаа оруулж ирдэг болсон. Жалга довны үзэл өөрчлөгдөж, асуудлыг том хүрээнд хардаг болж байна. Бүсүүд хоорондоо өрсөлдөх боломж үүсэж байгаа нь хамгийн чухал. Тухайлбал, Говийн бүс эрчим хүчний асар их нөөцөө ашиглан сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрүүд барьж дотоодын хэрэгцээг хангаад, цаашлаад экспортолно. Баруун бүс мах, ноос, арьс ширний үйлдвэрүүдийг бий болгоод хөрш зэргэлдээ улс орнуудаар дамжуулан зах зээлээ тэлье гэх мэт санаачилга гарч байна.

ахуйн нэгж, байгууллагууд. Энэ бодлогын ач холбогдлыг иргэдэд хүргэх, тэдний санал, шинэ санаачилгыг тусгах нь нэн чухал. “Бүсийн хөгжлийн боломж, инновац технологи нэвтрүүлэх, иргэд орлогоо нэмэгдүүлэх” гэх мэтчилэн өргөн хүрээтэй оролцоог хангаж идэвхжүүлэх цогц хөтөлбөрүүд хэрэгжинэ. Жишээ нь мэтгэлцээн, хэлэлцүүлгээс эхлээд инновац технологи, шинэ нээлт, бүсийн хөгжлийг дэмжихүйц төсөл хөтөлбөрийн нээлттэй уралдаануудыг иргэд, олон нийтийн дунд зарлаж орон даяар эхлүүлнэ. Мөн оюутан, сурагчдын дунд эсээ бичлэгийн уралдаан, мэтгэлцээн зохион байгуулж, инновац, технологийн шалгаруулалт явуулна. Аймаг, орон нутгийн түвшинд хэлэлцүүлгүүд хийнэ. Бид дээрээ бодлого яриад, доороо гүйцэтгэлгүй үлддэг алдааг давтахгүй байхыг зорьж байна.

Өмнө нь бүсчилсэн хөгжил ажил хэрэг болоогүй гол шалтгаан нь “дундын холбоос” байгаагүйд оршино. Тиймээс бид “Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн”-г байгуулсан. Энэ хүрээлэн бол бүсчилсэн хөгжлийн бодлогын “уураг тархи”, төр, орон нутаг, хувийн хэвшил, судалгааны хүрээлэнгүүдийг холбох “гүүр” байх юм. Мөн эрдэмтэн судлаачдын зөвлөлийг байгуулж, бодлого, шийдвэрийг шинжлэх ухааны үндэслэлтэй гаргана. Ингэснээр залгамж чанарыг алдалгүй, улс төрийн нөхцөл өөрчлөгдсөн ч бодлогоо үргэлжлүүлдэг байх тогтолцоо бүрдэнэ.

Дараагийн 3–4 жил шийдвэрлэх үе

-Засгийн газрын ирэх 3–4 жилийн төлөвлөгөөнд ямар ажлуудыг түлхүү хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн бэ?

-Энэ 3-4 жил бол бүсчилсэн хөгжлийн бодлогоо “араамнаас нь гажаахгүй” зөв голдиролд



нь оруулж зангидах чухал үе. Бүс бүрийг холбосон дэд бүтэц, хөгжлийн төвүүдийг байгуулж, хөрш орнууд болон бусад улстай гадаад хамтын ажиллагаагаа эрчимжүүлнэ. Үүнд:

- Татварын бодлогоор бүсчилсэн хөгжлийг дэмжиж, хөрөнгө оруулалт татах ажлуудаа эрчимжүүлнэ.
- Бизнес төв, аялал жуулчлалын төв, шинжлэх ухаан, инновац хөгжлийн төв зэрэг томоохон төслийн зураг төсөвт улсын төсвөөс 60 тэрбум төгрөг баталсан.
- Өв соёл, амьдралын хэвшил, соёл урлаг, спортын арга хэмжээгээрээ бүсүүд хоорондоо ялгарч, жуулчдыг татах, үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлэн брэнд бүтээгдэхүүн бий болгох зорилго ажил хэрэг болно.
- Жижиг, дунд, бичил үйлдвэрлэгчдийг кластер тогтолцоонд оруулж, бүтээгдэхүүнийг нь дотоод, гадаадын зах зээлд гарахад тусална. Бүсчилсэн хөгжлийн тусгай болон чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулбал бүх төрлийн татвараас 5–10 жил чөлөөлөх зэрэг таатай орчин бүрдүүлнэ.

Ирэх 30 жилийн итгэл үнэмшил

-Бид өмнө нь сонгуулийн мөчлөгтэй холбоотойгоор бодлогоо ойр ойрхон өөрчилж, хөгжлийг хойш чангаасан түүхтэй. Бүсчилсэн хөгжлийн бодлого ийм байдалд дахин өртөхгүй гэдэгт найдаж болох уу?

-Зөв бодлого тогтвортой байх ёстой. Бид олон жил эргэж буцаж явсны эцэст "Алсын хараа 2050", "Шинэ сэргэлтийн бодлого", "Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал"-аа тодорхой болголоо. Түүнтэй уялдаад 2024 оны УИХ-ын сонгуулийг бүсчилж явуулсан. Аймаг, сум, баг гэсэн жалга довны сэтгэлгээнээс улбаалсан жижиг тойрог, жижиг ашиг сонирхлыг аль болох багасгахыг зорьсон хэрэг. Одоо ухарвал бүхнийг эхнээс нь шинээр эхэлнэ. Тэгвэл бүр ухарна, бүр их алдана. Энэ бодлогоо илүү сайжруулж цааш нь өргөжүүлж, улс үндэстний түвшний сонгуулийн тогтолцоо руу шилжих ёстой. Нэг жижигхэн нутаг дэвсгэрийн төлөө биш, бүхэл бүтэн улсынхаа төлөө бодлого ярьдаг, улстөрч бүр үндэсний хэмжээний том зорилго

дэвшүүлдэг болох нь шинэ цагийн хөгжлийн сэргэн мандалтын том хөдөлгүүр болно. Монгол Улс яг одоо түүхэн хөгжлийнхөө эхлэл цэг дээр ирээд байна.

-Ирэх 30 жилд Монгол Улсын хөгжлийг Та хэрхэн төсөөлж байна вэ?

-Би маш өөдрөгөөр хардаг. Бүсчилсэн хөгжлийн бодлого, зорилго бол амьдралын гашуун сургамж дундаас олж авсан, хамгийн зөв шийдэл. Ковидын дараах эдийн засгийн болон геополитикийн олон хямрал, хөршүүдийн зах зээл хаагдсан гээд бид маш хүнд нөхцөлийг давлаа. Энэ бүхний эцэст “өөрөөр хөгжих хэрэгтэй” гэсэн ухааралд Монгол хүн бүр хүрсэн гэж боддог. Тиймдээ ч нийгмийн шаардлага асар өндөр болсон гэж ойлгодог.

Боомтын сэргэлтийн бодлого, төмөр замын томоохон төслүүд, экспортын гарцыг нэмэгдүүлэх хэрэгцээ, эдийн засгийн аюулгүй байдлыг дотооддоо хангах шаардлага, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Хүнсний хувьсгал, Цагаан алт хөтөлбөр зэрэг нь энэ бодлогын салшгүй хэсэг. Ирээдүйн 3–4 жилийг зөв ашиглавал манай эдийн засаг энергиэрээ өсөж, хурдтай хөгжинө. Монгол Улс 30, 50 жилийн дараа ч илүү хүчирхэг, нээлттэй, бүсчилсэн хөгжлөөрөө манлайлсан тогтвортой хөгжлийн загвар улс болж чадна.

Шинэ цагийн сорилт ба гадаад хүчин зүйлс

Олон улсын тогтворгүй байдал, дайн дажин, энх тайван, аюулгүй байдлын асуудлууд хурцдаж байгаа энэ үед бид илүү ухаалаг байх ёстой. Хурдтай хувьсан өөрчлөгдөж буй дэлхий ертөнц, геополитикийн таахын аргагүй хурцадмал үйл явцын дунд Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ, Засгийн газрын сүүлийн жилүүдэд барьж ирсэн бодлого, үзэл баримтлал маш зөв чиг зүгт явж байгааг онцлох нь зүйтэй.

Гадаад харилцааны сайд ч маш сайн ажиллаж байна. Сонголтоор бус хувь заяагаар мөнхийн хөрш болцгоосон ОХУ, БНХАУ-тай харилцах харилцаа манай гадаад бодлогод үргэлж тэргүүлэх байр суурьтай байж ирсэн.

Үүний зэрэгцээ гуравдагч хөршүүдтэйгээ стратегийн болон иж бүрэн түншлэлийн харилцаагаа өргөжүүлж, үр ашигтай бөгөөд тэнцвэртэй харилцах нь манай улсын язгуур эрх ашигтай нийцнэ. Цаашдаа ч Монголын төр хэн нэгний явцуу эрх ашиг, явуургүй шүүмжлэлээс ангид байж гагцхүү улс эх орны оршихуйн чухал үндэс болсон гадаад харилцааны илүү ухаалаг, уян хатан, оролцоотой, нарийн судалгаа тооцоотой, цаг үеийн мэдрэмжтэй бодлогыг бэхжүүлэхэд онцгой анхаарал хандуулсаар байх ёстой.

Сүүлийн үед хоёр хөрштэй төдийгүй гуравдагч хөршүүдтэй зориуд үл ойлголцуулан, эх орныг маань хагалан бутаргах гэсэн элдэв явуулгууд их явж байна. Бид хөндлөнгийн санаатай, санамсаргүй аливаа явуулга, хатгаас, сэтгэлийн хөөрөлд автсан үйлдлээс улбаалан уламжлалт, найрсаг харилцаатай хоёр хөршөөсөө нүүр буруулж, гуравдагч хөршүүдтэйгээ харилцах хаалгаа хаачихаад гадаад ертөнцөд танигдах, хүлээн зөвшөөрөгдөж, дэлхий нийттэй хөл нийлүүлэн хөгжих, урагшлах ямар ч боломжгүй шүү дээ.

Зэрэгцэн оршиж буй тохиолдолд харилцан эв найртай, бусад бүх улс үндэстэнд хүндэтгэлтэй хандаж байж хүндэтгэл итгэлийг харилцан бий болгоно. Бид улс орны хөгжлөө урагшлуулах нэг хүсэл зорилготой ард түмэн. Тиймээс дотооддоо чадавхжих, хөгжиж, сэргэн мандах нь бидний нийтлэг эрх ашиг байх ёстой. “Бүсчилсэн хөгжил бол шинэ цагийн сэргэн мандалтын бодлого” гэж миний хэлдэг нь ийм учиртай. Энэ бол Монгол Улс дэлхий нийттэй хөл нийлүүлэн хөгжин урагшлах хамгийн зөв бөгөөд цорын ганц зам юм.

Ярилцлагын төгсгөлд...

Хурдны галт тэрэг Узбекистан улсын Самарканд–Ташкентын хооронд хоёр цаг явдаг. Бидний ярилцлага ч ижил хугацаанд өрнөж дуусахад, галт тэрэг Ташкент хотын өртөөнд ирлээ.

25 жил эдийн засгийн чиглэлээр бичиж ирсэн сэтгүүлч миний хувьд 700–800 жилийн өмнө өвөг дээдсийнхээ байлдан дагуулж, төвхнүүлж байсан Дундад Азийн төвд, Монгол Улсын Шадар сайдтай уулзан улс эх орныхоо хөгжлийн талаар ярилцсан нь үнэхээр онцгой сэтгэгдэл төрүүллээ.

Дэлхийн түүхэнд их гүрэн мандаж, доройтож, оронд нь шинэ улс гүрэн бий болж, амьдрал ээлжлэн үргэлжилсээр ирсэн нь жам. Гэвч дэлхийн талыг эзэгнэн явсан Монголын эзэнт гүрний шууд өв залгамж үр сад нь өнөөдөр ч Төв Азийн цээжинд тусгаар улсаа тунхаглан амьдарч байгааг харахад бахархахгүй байхын аргагүй. Одоо бид урвалзан савлах шүүмжит сэтгэлгээгээ орхиж, илүү өргөнөөр сэтгэж, өөрсдийгөө дэлхийн хөгжилтэй уялдуулан өндийх цаг иржээ.

“Бүсчилсэн хөгжлийн бодлого бол зах зээлээ тэлэх, орчин цагийн сэргэн мандалтын бодлого юм” гэж С.Амарсайхан сайд хэлсэн. XIII зуунд манай Их хаад Дундад Ази руу зах зээлээ тэлэх бодлогыг Торгоны замаар дамжуулан хэрэгжүүлж, ард иргэдийнхээ аж амьдралыг нь дээшлүүлж байсан бол өнөөгийн төрийн бодлого ч бүс нутаг, гадаад ертөнц рүү чиглэж байна. Энэ нь Монгол Улсын хөгжлийн хамгийн зөв гарц төдийгүй, сэтгүүлч миний хувьд ч бүсчилсэн хөгжил бол ирээдүйн итгэл найдвар, хөгжлийн гол тулгуур гэж онцлон тодотгомоор байна.

Д.Бэхбаяр

/Mongolian Economy сэтгүүлийн Эрхлэгч, сэтгүүлч/

Узбекистан, Самарканд–Ташкент, 2025 оны хоёрдугаар сар

Аялал жуулчлал



Цэнхэр гарагийн өнцөг бүрээс нүүдэлчдийн өв соёл, үзэсгэлэнт байгаль, зэрлэг ан амьтад, түүхийн асар их баялгийг үзэхээр Монгол орныг зорих их урсгалыг татахад Бүсчилсэн хөгжлийн бодлого чиглэнэ.

Аялал жуулчлал бол Монгол Улсын хөгжлийн тэргүүлэх салбар. Тийм учраас Засгийн газар 2024-2026 оныг Монголд зочлох жилээр зарласан. 2023 онд түүхэндээ анх удаа 650 мянган жуулчин авч, 1.0 тэрбум ам.доллар давсан орлого олсон нь тус салбарын хувьд бахдам амжилт болов. 1.3 тэрбум ам.доллар бол уул уурхайн салбарын дараа орж буй тоон үзүүлэлт. Тэгэхээр аялал жуулчлал хөгжлийн ямар их потенциал, нөөцтэй, эдийн засагт ямар их үүрэгтэй салбар вэ гэдгийг харуулж байгаа юм.

Үзэсгэлэнт, онгон зэрлэг байгаль маань гадаадын жуулчдын сонирхлыг соронзон мэт татдаг. Мөн түүх соёлын үнэт өвүүдээрээ бид бахархах учиртай. Өвөг дээдсийн маань туулсан хатуу, ширүүн замууд бидэнд түүхийн асар их баялаг нөөцийг үлдээсэн. Энэхүү өв соёлын түүхэн нөөцөө эдийн засгийн эргэлтэд оруулж, байгальд ээлтэйгээр хөгжүүлж, гадаадын жуулчдыг татсанаар хурдтай хөгжлийг бий болгох боломжтой.

Бүсчилсэн хөгжлийн бодлогоор аялал жуулчлалын салбарыг мөн газар зүйн онцлогоор нь бүсчлэн хөгжүүлэхээр төлөвлөсөн. Аялал жуулчлалын тусгай бүс, паркууд, тухайлбал, Хөвсгөл нуур орчмын

Go Mongolia





ХЭРЭГЖИХ ТӨСЛҮҮД

- Хөвсгөл нуур орчмын аялал жуулчлалын тусгай бүс
- “Төв Азийн түүх соёлын голомт” цогцолбор
- Өндөр гэгээн Занабазарын бүтээн туурвисан соёлын өвд тулгуурласан цогцолбор
- Түүх, соёлын нөөц, буйр нуурыг түшиглэсэн хил орчмын болон хил дамнасан аяллыг хөгжүүлэх аялал жуулчлалын тусгай бүс
- “Кино, контент үйлдвэрлэлийн цогцолбор”
- Алтай-хангайн нуруу, Увс нуурын ай сав, их нууруудын экосистемд түшиглэсэн тусгай бүс
- Алтайн нурууны байгаль соёлын өвд түшиглэсэн эко парк
- Дундговь аймгийн Цагаансуварга орчмын палеонтологийн нөөцөд түшиглэсэн аялал жуулчлалын тусгай бүс
- Сүхбаатар аймгийн Дарьганга суманд тахилгат хайрхан уулс түшиглэсэн байгаль, соёлын өвийн цогцолбор
- “Нүүдэлчин” дэлхийн соёлын наадмын тусгай бүс
- Хөшигийн хөндийн аялал жуулчлалын тусгай бүс

аялал жуулчлалын тусгай бүс, Төв Азийн түүх, соёлын голомт цогцолбор, Нүүдэлчин дэлхийн соёлын наадам, Хөшигийн хөндийн аялал жуулчлалын тусгай бүс гэх мэт. Монгол бол палеонтологийн олдвороор дэлхийд эхний тавд бичигддэг улс. Аварга биетэй, өвсөн болон махан идэшт Тарбозавр, Протоцератопс, Велосираптор, Овираптор зэрэг үлэмж биет гүрвэлүүд олдсон үлэг гүрвэлийн өлгий нутаг. Цэнхэр гарагийн өнцөг бүрээс нүүдэлчдийн өв соёл, үзэсгэлэнт байгаль, зэрлэг ан амьтад, түүхийн асар их баялгийг үзэхээр Монгол орныг зорих их урсгалыг татахад Бүсчилсэн хөгжлийн бодлого чиглэнэ.

Монгол Улсын Засгийн газраас өнгөрсөн жилүүдэд “Welcome to Mongolia” уриан дор жуулчдыг Монголд аялахыг уриалсан

бол энэ жилээс Go Mongolia уриатайгаар дэлхий рүү чиглэсэн сурталчилгааг хийж эхэлсэн. Яагаад Монголд ирэх ёстой вэ брэндингийг хөгжүүлж байна. Олон улсын нэртэй хэвлэл мэдээллийн хэрэгслүүд Монголыг заавал аялах ёстой 10 улсын нэгээр тодруулж, Монгол Улсад аялах 10 шалтгаан хэмээн бичиж байна. Тухайлбал, CNN, Financial times, Washington post зэрэг 40 гаруй мэдээллийн хэрэгслээр Монгол Улсын тухай мэдээлэл, нэвтрүүлэг гарснаар 2023 он болон 2024 онд олон мянган жуулчин Монголд ирж аялсан билээ. Монгол Улс байгалийн шавхагддаг нөөц уурхайгаас гадна байгалийн шавхагдашгүй нөөцөө ашиглаж, хөгжүүлж, жуулчдыг татаж, улс орноо богино хугацаанд хөгжүүлэх бодлогоо ийн тодорхойллоо. Go Mongolia.

ҮНДЭСНИЙ ҮНЭТ ЗҮЙЛ




ПАЛЕОНТОЛОГИЙН
ОЛДВОРООР ДЭЛХИЙД

5 -Т ОРДОГ



ОРОН НУТГИЙН БҮСЧЛЭЛ- ХӨГЖЛИЙН ТӨВҮҮД



21 + 70

АЙМГИЙН ТӨВ


СУМ, СУУРИН ТӨВ

91

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ



ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН ТӨВҮҮДЭД ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ, ХУДАЛДАА, БИРЖ, ТЭЭВЭР ЛОГИСТИКИЙГ ЦОГЦОЛБОР ХЭЛБЭРЭЭР НЭГДСЭН ӨРТГИЙН СҮЛЖЭЭНД ХОЛБОЖ, КЛАСТЕРЫН ЗАРЧМААР ХӨГЖҮҮЛЭХ ХУВИЙН ХЭВШИЛ, ХОРШООДЫГ ТЭРГҮҮН ЭЭЛЖИНД ДЭМЖИНЭ.




- ☑ ГАЗАР ЗҮЙН ЗААЛТ БҮХИЙ ОРОН НУТГИЙН БРЭНД
- ☑ ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮН БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭХ, АНГИЛАН ЯЛГАХ, ТОРДОХ, ҮЙЛДВЭРЛЭХ
- ☑ ТЭЭВЭР ЛОГИСТИК, ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ КЛАСТЕР

ТЭЭВЭР ЛОГИСТИКИЙН НЭГДСЭН СҮЛЖЭЭГ БАЙГУУЛНА



” ХИЛИЙН БООМТ, ЧӨЛӨӨТ БҮС, ЭДИЙН ЗАСГИЙН КОРИДОРЫН ГОЛ ЗАНГИЛАА ЦЭГҮҮДЭД ОЛОН УЛСЫН ТЭЭВЭР ЛОГИСТИКИЙН ТӨВ, БҮСИЙН ТҮВШНИЙ ТЭЭВЭР ЛОГИСТИКИЙН ТӨВ, БАРАА, БҮТЭЭГДЭХҮҮН ХАНГАН НИЙЛҮҮЛЭХ АНХАН ШАТНЫ ОРОН НУТГИЙН ЛОГИСТИКИЙН ТӨВҮҮДИЙГ БАЙГУУЛЖ, ТЭДГЭЭРИЙГ АВТО БОЛОН ТӨМӨР ЗАМААР ХОЛБОНО.





ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛ

БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН
БОДЛОГО ХУВИЙН ХЭВШИЛД
ТУЛГУУРЛАНА ГЭДГИЙГ
БОДЛОГО ТОДОРХОЙЛОГЧИД
ХЭЛЖ БАЙНА.

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын гол зорилго нь төр хувийн хэвшил хамтарч ажилласнаар гадаад, дотоодын зах зээлийг нээх хувийн хэвшлийг борлуулалтаар нь дэмжих нөхцөл бүрдэнэ.

Өнгөрсөн 30 жилд улс орны хөгжилд төр түлхүү үүрэг гүйцэтгэж ирсэн бол ирэх 30 жилд

хувийн хэвшлийн оролцоог түлхүү байлгана гэдэг зарчим шинэ хөгжлийн бодлогын гол түлхүүр байна.

Бүсчлэн хөгжүүлэх бодлого нь тэр чигтээ бизнесийг, хувийн хэвшлийг дэмжсэн, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татахад чиглэж байгаа юм. Бүсийн хөгжлийг дэмжих бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөрүүдийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хамтран хэрэгжүүлэхээр заасан. Үүний тулд бизнесийн таатай орчныг бүрдүүлэхэд төр анхаарч ажиллана.

Бүсийн эдийн засгийн

тэргүүлэх чиглэлтэй уялдуулан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг татвар, хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжих, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх, Шинэ хоршоо хөдөлгөөнөөр хоршоологч, үйлдвэрлэгчдийг дэмжин жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, гарааны бизнес, инновацын төслүүдийг мөн дэмжиж, эдийн засгийн эргэлтэд оруулахыг зорьж буй.

Засгийн газраас 14 мега төслийг хэрэгжүүлэхээр зарласан. Тус төслүүдийг мөн бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан тухайн бүсүүдэд бүтээн

ОРОН НУТГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПАРК

Хатуу дэд бүтцийн дэмжлэг:

- Дулаан хангамж
- Цахилгаан хангамж, холбоо мэдээлэл, ус хангамж
- Ариутгах татуурга зах зээлийн холболт

Зөөлөн дэд бүтцийн дэмжлэг:

- Хөнгөлөлттэй зээл
- Маркетинг, борлуулалтаар дэмжих
- ТЭЗҮ, зураг төсөв брэнд хөгжүүлэлт стандарт
- Инновац, технологи дамжуулалт
- Үржил, селекц
- Генетик нөөц
- Шинэ хоршоо
- Төрийн худалдан авалт



байгуулалтууд өрнүүлж, хөгжүүлнэ. Эдгээр 14 мега төсөлд хүнд үйлдвэр, ган, төмөр, зэсийн үйлдвэрүүд, эрчим хүч, зам тээврийн төслүүд багтаж буй бөгөөд томоохон хөрөнгө оруулалт татаж хэрэгжүүлэх бүтээн байгуулалтууд юм.

Том хэмжээний үйлдвэр, компаниудыг дагаж жижиг, дунд компаниуд хөгждөг. 14 мега төслийг дагаад тухайн бүс, орон нутагт бизнес идэвхжиж, эдийн засаг өсөж, иргэд хангалуун сайхан амьдрах боломжтой болно. Нөгөө талаар төрөөс бизнесүүдийг идэвхжүүлэх, сэргээх, нэгдэх, хорших, дагнах боломж нөхцөлүүдийг бий болгоно. Өөрөөр хэлбэл, төр бизнес эрхлэх эрх зүйн орчныг сайтар бүрдүүлж, зөөлөн, хатуу дэд бүтцүүдийг бий болгоно гэдгээ Бүсчилсэн хөгжлийн бодлогоор тодорхойлоод олон хуульд нэмэлт өөрчлөлт хийхээр ажиллаж байна.

Бүсчилсэн хөгжлийг эрчимжүүлж, эдийн засгийн өсөлтийг бий болгохын тулд хувийн хэвшлийг оролцоог дэмжинэ. Чөлөөт бүс, тусгай бүс, үйлдвэр технологийн паркад үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд төрөл бүрийн татварын хөнгөлөлт урамшуулал үзүүлнэ. Үйлдвэрлэл технологийн паркад үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг нэгдсэн зохион байгуулалттайгаар экспортлох орчныг бүрдүүлнэ. Аж ахуйн нэгжүүдийн борлуулалтын сувгуудыг олон улсын жишгээр дэмжиж хөгжүүлэхийг чухалчилж байна.

Бүсчилсэн хөгжлийн бодлогоор хүнд үйлдвэрлэлийг цогцлооно. Тухайлбал, Эрдэнэтэд зэс боловсруулах үйлдвэр, Дарханд ган боловсруулх үйлдвэр, Сэлэнгэ Хөтөлд Үйлдвэр технологийн парк

(ҮТП), Баганхангайд шилний үйлдвэр барьж байгуулах гэх мэт.

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгуурласан шинэ татварын бодлого хэрэгжүүлнэ. Үүнд: **Нэгдүгээрт**, боловсруулах үйлдвэрлэлийг дэмжиж, бүс бүрийн онцлогоор нь татварын ялгаатай бодлого хэрэгжүүлнэ. **Хоёрт**, салбар харгалзахгүйгээр боловсруулах үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг гаалийн татвараас чөлөөлөх, НӨАТ-ын зохицуулалт хийнэ. /Архи, тамхи гэх мэт салбарт хориглох заалт хэвээр/ **Гуравт**, нийгмийн салбарт хандив өргөсөн, хөрөнгө оруулалт хийсэн хөрөнгө оруулагч, аж ахуйн нэгжүүдийн жилийн борлуулалтын орлогын 1 хүртэлх хувийг татвараас чөлөөлнө.

Бүсчилсэн хөгжлийн бодлогыг бусад улс орон ялангуяа хоёр хөрш орны хөгжлийн бодлоготой уялдуулна. Тиймээс боомтуудыг сэргээж, богино хугацаанд хөгжүүлж, гадаад худалдааны урсгалыг түргэн шуурхай явуулахад чиглэсэн бодлого хэрэгжүүлнэ. Түүнчлэн Евро-Азийн эдийн засгийн коридор, Бүс ба зам зэрэг хөтөлбөр, төслүүдтэй өөрийн орны хөгжлийн бодлогоо уялдуулснаар, мөн Бүс нутгийн эдийн засгийн


ХҮНД ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПАРК

- Зэс боловсруулах Цогцолбор / Эрдэнэт/
- Дархан-ган боловсруулах цогцолбор
- Сэлэнгэ- ХӨТӨЛИЙН УТП
- Бор-Өндөр- ЗҮҮН БҮСИЙН УТП
- Баганхангайд шилний үйлдвэр Багануурт УТП
- Говь-Алтай- шохойн болон магнетизийн үйлдвэр
- Баянхонгор- Хангайн бүсийн УТП
- Дорноговь- Газрын тос боловсруулах үйлдвэр
- Өмнөговь- Нүүрс-хими цогцолбор
- Говийн бүсийн УТП
- /Алтанширээ, Гэрэлт- Говь/

интеграцид нэгдэж, шинэ зах зээлүүд нээж, хувийн хэвшлийг дэмжсэнээр Монгол Улс хурдтай хөгжих нөхцөл бүрдэх юм. Энэ нь шинэ хөгжлийн бодлогын амин сүнс байх юм.



БҮС НУТГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ИНТЕГРАЦИД НЭГДЭЖ, ЗАХ ЗЭЭЛИЙГ НЭЭХ ЗАМААР ХУВИЙН ХЭВШЛИЙГ БОРЛУУЛАЛТЫН СУВГААР ДЭМЖИНЭ



ХҮЧИН ТӨГӨЛДӨР ХЭРЭГЖИЖ БАЙГАА ЧӨЛӨӨТ ХУДАЛДААНЫ ХЭЛЭЛЦЭЭРҮҮД

ЕВРОПЫН ХОЛБООНЫ ХӨНГӨЛӨЛТИЙН ЕРӨНХИЙ СИСТЕМ GSP+

7,200 ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ТАРИФЫН ХӨНГӨЛӨЛТТЭЙ

МОНГОЛ ЯПОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ТҮНШЛЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР:

5,200 МОНГОЛ ТАЛААС

9,300 ЯПОН ТАЛААС

ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ТАРИФЫН ХӨНГӨЛӨЛТТЭЙ

АЗИ, НОМХОН ДАЛАЙН ОРНУУДЫН ХУДАЛДААНЫ ХЭЛЭЛЦЭЭР:

БНСУ, БНХАУ, ЭНЭТХЭГ, БАНГЛАДЕШ, ЛАОС

10,667 ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ТАРИФЫН ХӨНГӨЛӨЛТТЭЙ



ШИНЭЭР ТӨЛӨВЛӨЖ БУЙ ЧӨЛӨӨТ ХУДАЛДААНЫ ХЭЛЭЛЦЭЭРҮҮД

ОХУ-РУУ 375 ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ТАТВАРГУЙ ЭКСПОРТ ХИЙХ ЧӨЛӨӨТ ХУДАЛДААНЫ ТҮР ХЭЛЭЛЦЭЭР

БНСУ-ТАЙ ЭДИЙН ЗАСГИЙН ТҮНШЛЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР

БНХАУ-ТАЙ ЧӨЛӨӨТ ХУДАЛДААНЫ ХЭЛЭЛЦЭЭР

Бодлогын байр суурь



У.Хүрэлсүх:
Монгол Улсын
Ерөнхийлөгч

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод”, “Хүнсний хувьсгал”, “Цагаан алт”, “Эрүүл Монгол хүн”, “Илгээлт 2100” үндэсний хөдөлгөөн, хөтөлбөр “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-тай нягт уялдан хэрэгжсэнээр Монгол Улсын хөгжил дэвшил монгол хүн бүрд хүртээмжтэй, өгөөжтэй болох ёстой.



Л.Оюун-Эрдэнэ:
Монгол Улсын
Ерөнхий сайд

Монголын төр засаг, бүсчилсэн хөгжилд хандах хандлагаа өөрчилж, бодлого, үзэл баримтлалаа баталлаа. Харин бид одоо хандлагаа өөрчлөх ёстой. Бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлснээр хөдөөгөөс хот руу биш, хотоос хөдөөг зорьсон их нүүдэл эхэлнэ гэдэгт итгэлтэй байна.



Л.Гантөмөр:
Монгол Улсын
Тэргүүн Шадар сайд

Бүсчилсэн хөгжлийн бодлого ирэх жилүүдийн Засгийн газрын хамгийн чухал тэргүүлэгч чиглэл. Тухайн бүсүүдэд хөгжлийн төлөө тодорхой бодлогууд, хуулиудыг тус тусад нь баталж хэрэгжүүлэх цаг үе ирж байна.



Д.Амарбаясгалан:
УИХ-ын дарга

Аймаг, сум бүр өөрийн боломжид түшиглэсэн хөгжлийн бодлого гаргаж, иргэн бүр ижил түвшинд амьдрах, хөгжих боломжийг бүрдүүлэх нь бүсчилсэн хөгжлийн үндсэн зорилго юм. Тиймээс орон нутагт эрчим хүч, зам, дэд бүтэц, нийгмийн үйлчилгээг зах зээлийн тэгш хүртээмжтэй нөхцөлөөр хангах, төсвийн бодлогоор дэмжиж, эрх зүйн орчныг боловсронгуй болгох нь энэ парламентын шийдэх ёстой чухал ажил мөн.



С.Амарсайхан:
Монгол Улсын
Шадар сайд

Бүсчилсэн хөгжлийн бодлого бол Монгол Улсын ирээдүйн хөгжлийн хамгийн зөв бөгөөд цорын ганц шийдэл.



Т.Доржханд:
Монгол Улсын
Шадар сайд

Орон нутаг хөгжих боломж нь зах зээл үүсгэх буюу хүний төвлөрөл юм. Дараа нь зах зээлдээ чиглэсэн зам, эрчим хүч буюу дэд бүтэц бөгөөд эдгээрийг ажил хэрэг болгох суурь нь бүсчилсэн хөгжил юм.



Н.Учрал:
*Монгол Улсын сайд,
ЗГХЭГ-ын дарга*

Монгол Улсын Засгийн газар "E-Cabinet" системийг нэвтрүүлж төрийн албаны ажлын гүйцэтгэлийг тоогоор хэмжихээс гадна аймаг, сум, орон нутгийн амьдралын чанарыг бодит цаг хугацаанд хянаж, шаардлагатай арга хэмжээг цаг алдалгүй авч байна.



В.Батцэнгэл:
*МУИС-ийн харьяа
Хот бүс нутгийн
хөгжлийн судалгааны
хүрээлэнгийн захирал,
Доктор, Профессор*

Бүсчилсэн хөгжил бол Монголчууд бид газар нутгаа нээлттэйгээр хамтран ашиглаж ирсэн орон зайн уламжлалт чөлөөт сэтгэлгээнд зохицсон, дэлхийн өндөр хөгжилтэй улс орнууд өөрсдийн хөгжлийн бодлого төлөвлөлтөндөө амжилттай ашиглаж бодит үр дүнд хүрч баталгаажсан байдаг. Тогтвортой хөгжлийн аливаа асуудлуудыг шийдвэрлэхийн тулд нутаг дэвсгэрийг илүү оновчтой зохион байгуулах орон зайн төлөвлөлтийн өвөрмөц хандлага юм.



Р.Ринчинбазар:
*МУИС-ийн
профессор,
Шинжлэх ухааны
доктор*

Эдийн засгийн бүсчлэлийн мөн чанар нь нутаг дэвсгэрийг оновчтой зохион байгуулах, үйлдвэрлэл, салбаруудыг зохистой байршуулах, дэд бүтцийн нэгдсэн сүлжээ байгуулах, бүсүүдийн төрөлжилт, харилцан уялдааг дэмжих замаар бүс нутгуудад ард иргэд ажиллаж, амьдрах харьцангуй жигд нөхцөлийг бүрдүүлэхэд оршино. Цаашлаад төрөөс орон зайн хөгжлийг хөтлөн чиглүүлж, төлөвлөн зохицуулах, шударга ёсны зарчмыг хэрэгжүүлэх механизм юм.



Н.Тогтох:
*УИХ-ын гишүүн асан,
Шинжлэх ухааны
гавьяат зүтгэлтэн,
Доктор*

Транзит дэд бүтцийн тэнхлэгүүдийн нэгдсэн сүлжээнд суурилсан Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал нь Эзэн Чингис хаанаас эхлэлтэй "Монгол төрийн уламжлалт бодлого"-ын өнөөгийн хувилбар юм.



Г. Батгүвшин:
*Бүс нутаг
судлаач, Доктор,
Профессор*

Монгол Улс бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг хөгжлийн гол асуудал болгож байгаад би маш таатай байгаа юм. Учир нь аль ч улс орны хувьд зарим нутаг дэвсгэр нөгөөгөөсөө хөгжлийн суурь үзүүлэлтийн хувьд ялгаатай байдаг. Тиймээс бид бүсчилж хөгжүүлэх замаар сул хөгжилтэй бүсүүдэд төрийн оновчтой бодлого хэрэгжүүлэх, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх замаар хөгжлийн түвшнийг жигдрүүлэх нь чухал юм.



Д.Эрдэнэбаяр:
*Бүсчилсэн
хөгжлийн үндэсний
хүрээлэнгийн гүйцэтгэх
захирал, Доктор,
Дэд профессор*

Хөгжлийн философи, үндэсний үнэт зүйл талаас авч үзвэл, түүх соёл, газар нутгийн асар их нөөцтэй, байгаль дэлхийгээ хамгаалж, шүтэж амьдардаг монголчуудын хувьд бүсчилсэн хөгжлийн загвар бол хамгийн оновчтой шийдэл.

Д.ЭРДЭНЭБАЯР: Бүх түвшинд нэгдсэн нэг ойлголттой болж, нэг зүгт харж байж Бүсчилсэн хөгжлийн бодлого амжилттай хэрэгжинэ

Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэнгийн Гүйцэтгэх захирал, доктор, дэд профессор Д.Эрдэнэбаяртай ярилцлаа. Бид бүсчилсэн хөгжлийн бодлогын шинжлэх ухааны үндэслэл, онол практикийн хослол, бүс нутгийн хөгжлийн бодлого, уялдаа холбооны талаар ярилцсан юм. Д.Эрдэнэбаяр нь бүсчилсэн хөгжлийн асуудлыг багагүй хугацаанд судалж, төрийн бодлого болгох ажлыг ахлан ажиллаж, бодит амьдралд буулгахын төлөө ажиллаж ирсэн мэргэжилтэн юм. Тэрбээр “Эдийн засгийн бүсчлэлд үндэслэн хөрөнгө оруулалтын хуваарилалтыг оновчтой болгох арга зүй” сэдвээр докторын зэрэг хамгаалсан билээ.



-Улс орноо бүсчлэн хөгжүүлэх бодлогын мөн чанарыг хэрхэн ойлговол зохилтой вэ?

-Улс орноо бүсчлэн хөгжүүлнэ гэдэг нь үндэсний эрх ашгийн үүднээс нутаг дэвсгэрийн орон зайн төлөвлөлт, хөгжлийн асуудлыг цогцоор нь авч үзсэнээр бүс нутаг бүрийн нөөц, чадавхыг нийтлэг зорилгын төлөө оновчтой зөв ашиглах, бүсүүдийн дагналт, төрөлжилт, хоршилт, хамтын ажиллагааны механизмыг үр дүнтэй ашиглахыг хэлнэ. Мөн

байгалийн баялгийг шударга хуваарилах, хүн амын шилжилт хөдөлгөөний эерэг, сөрөг үр дагаврыг зөв тооцох, ингэснээр бүс нутгуудын хоцрогдлыг арилгаж, үндэсний түвшинд орон зайн тэгш бус байдлыг багасгах явдал болно.

Монгол Улс зах зээлийн харилцаанд шилжих үйл явцад хүн ам хөдөөнөөс хот, суурин газарт олноор шилжин суурьшиж эхэлсэн нь ихээхэн хүндрэл бэрхшээл дагуулах болсон тул нутаг дэвсгэрийн орон зайн зохион

байгуулалтын шинэ тогтолцоонд тулгуурлан орчин үеийн зам тээвэр, эрчим хүчний сүлжээ, зах зээлийн дэд бүтцийг бүрдүүлэх шаардлагатай болсон. Ганц баримт дурдахад, 2024 оны байдлаар нийт хүн амын 70 хувь төв тэнхлэгийн таталцалд суурьшин амьдарч, газар нутгийн дөнгөж 0.3 хувийг эзэлдэг нийслэлд хүн амын 50 орчим хувь төвлөрч, иргэдийн төв рүү шилжих хөдөлгөөн саараагүй байна. Үүний улмаас ихэнх аймаг, сумын эдийн засгийн бие даан хөгжих, өрсөлдөх

чадвар сул, томоохон хот сууринд хүн ам, үйлдвэрлэл, үйлчилгээ хэт төвлөрч, хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа нэмэгдсэн билээ.

Ерөөс хүн ам бүхий аливаа нутаг дэвсгэрт үйлдвэрлэл, үйлчилгээ дэд бүтцээ дагаж хөгждөг зүй тогтолтой. Иймээс суурь дэд бүтцийг бий болгох нь төв, хөдөөгийн хоорондын эдийн засгийн зайг багасгаж, бүс нутгийн хөгжил, хот байгуулалтын уялдааг хангах, нийлүүлэлтийн сүлжээ бүрдүүлснээр нэг төвийн хамаарлыг бууруулах ач холбогдолтой юм.

-УИХ-аар 2024 онд баталсан Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын онол, арга зүйн үндэслэл нь юу байв?

-Эдийн засгийн бүсчлэлийн мөн чанарыг зөв ойлгон оновчтой бодлого боловсруулж, түүнийгээ тууштай хэрэгжүүлэхэд бүс нутгийн шинжлэх ухааны ололтыг ашиглах шаардлага зүй ёсоор тавигдсан. Анх XVII зуунд Европт үүссэн сонгодог парламентын тогтолцооноос үүдэлтэй бүс нутгийн хөгжлийн бодлогын практик зорилтуудыг судлан шийдвэрлэх талаарх онол, үзэл баримтлал нэлээд хугацааны туршид байгаль, нийгмийн олон салбарын уулзвар дахь судлагдахуун байсаар ирсэн. Өнгөрсөн зууны 30-аад оноос эдийн засгийн мужлал, бүсчилсэн хөгжлийн онол, сургаал; бүс нутгуудын кумулятив өсөлтийн концепц; агломерацийн концепц; тэнхлэгийн буюу таталцлын онол; локацийн буюу байршлын онол; системийн хандлагын чиглэлээр судалгаа эрчимтэй хийгдэж эхэлжээ.

Бид ч ямар онол арга зүйг үр дүнтэй ашиглаж болох вэ гэсэн асуултыг эрэлхийлэн байнга судалгаа, шинжилгээ явуулж ирсэн. Бодлогын баримт

бичгүүдийг ч боловсруулахдаа дээр дурдсан онолын үзэл хандлага, арга хэрэгслүүдийг түлхүү ашигласан. Өнөө цагт дэлхий нийтээр шинжлэх ухаан, технологийн хувьсгалд тулгуурлан аж үйлдвэржсэн нийгмээс мэдээлэлжиж, даяаршиж буй нийгэмд шилжиж байна. Энэ үеийн бас нэг онцлог нь улс орны хөгжил тодорхой “хөгжлийн төвүүд”-рүү “шилжиж” байгаа явдал юм. Иймээс орон зайн буюу бүс нутгийн шинжлэх ухааны судалгаанд тулгуурлан өөрийн орны онцлогт тохирсон хөгжлийн шинэ загварыг тодорхойлох шаардлага бий болсон гэж хэлж болно.

Иймээс бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын зорилго нь үндэсний түвшинд, газар нутгийн бүрэн бүтэн байдал, нутаг дэвсгэрийн нийгэм-экологийн тэнцвэр, эдийн засгийн бие даасан байдлыг хангах, газар зүйн байрлалын онцлогийн дагуу хөрш ба бүс нутгуудын орнуудтай харилцан түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлэх явдал юм. Мөн бүсийн түвшинд, бүсүүд хоорондоо зах зээлийн олон шижмээр холбогдон, харилцан нягт уялдаа хамааралтай, нэгдмэл бодлоготой ажилладаг байгууллага, компани, пүүсүүдийн газар зүйн тодорхой кластер үүсэх дэвсгэр суурь болох; аж ахуйн нэгжүүд, бизнесийн хүрээнд, байгаль, түүхий эдийн нөөцийг салбар дундын хоршилтоор бүрэн ашиглаж, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэн, дотоод, гадаад зах зээлд үр ашигтай борлуулалт, нийлүүлэлтийн сүлжээ бүрдүүлэх; хүн амын тухайд, ажиллаж, амьдрах газар орноо чөлөөтэй сонгон, байгаль, нийгмийн баялгийг бүтээлчээр хамтран эзэмшиж, ашгаас нь тэгш шударга хүртэн, эрүүл, аюулгүй орчинд тав тухтай амьдрах



Бид ямар онол арга зүйг үр дүнтэй ашиглаж болох вэ гэсэн асуултыг эрэлхийлэн байнга судалгаа, шинжилгээ явуулж ирсэн. Өнөө цагт дэлхий нийтээр шинжлэх ухаан, технологийн хувьсгалд тулгуурлан аж үйлдвэржсэн нийгмээс мэдээлэлжиж, даяаршиж буй нийгэмд шилжиж байна. Энэ үеийн бас нэг онцлог нь улс орны хөгжил тодорхой “хөгжлийн төвүүд”-рүү “шилжиж” байгаа явдал юм. Иймээс орон зайн буюу бүс нутгийн шинжлэх ухааны судалгаанд тулгуурлан өөрийн орны онцлогт тохирсон хөгжлийн шинэ загварыг тодорхойлох шаардлага бий болсон гэж хэлж болно.

орон зайн нөхцөл бүрдсэн байх, эдийн засгийн өсөлтийг хүн бүрт хүртээлтэй болгох явдал гэж үзсэн болно.

Энэ үүднээс харвал өнгөрсөн онд батлагдсан “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал” нь өргөн уудам Монгол орны байгаль-уур амьсгалын бүс, бүслүүрийн хувьсал өөрчлөлт, экологийн даац, чадавх,

нүүдлийн соёл иргэншлийн өв уламжлал, үндэстэн угсаатны зан заншил, иргэдийн хоршиж, хамтран ажиллаж, амьдрах сонирхол, хэрэгцээ зэргийг оновчтой тооцсон төрийн бодлогыг хэрэгжүүлэх эрх зүйн үндэс болж байгаа юм.

- Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг хэдий хугацаанд, ямар бүрэлдэхүүнтэй боловсруулж, улмаар төрийн бодлогын тэргүүлэх чиглэл хүртэл явуулсан процессоос товч ярина уу?

-Манай улс 1960-аад оныг хүртэл улс орныг нийтэд нь хамарсан бүсчлэлийн асуудлыг хөндөж, тусгайлсан бодлого хэрэгжүүлж байгаагүй юм. 1961 оноос эдийн засгаа бүсчлэлийн тогтолцоонд тулгуурлан хөгжүүлэх асуудлыг судлан макро бүсүүд тогтоож, бүсчилсэн хөгжлийн төлөвлөлт, үйлдвэрлэх хүчний хөгжил, байршлын 1990, 2000 он хүртэлх ерөнхий схем, хэд хэдэн удаагийн таван жилийн төлөвлөгөө боловсруулах арга зүйн үндэс болгон ашиглаж байв.

Харин 2001 онд Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг батлан бүсчлэлийн системийг хуульчлан тогтоож, бүсүүдийн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг баталсан. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хууль 2015 онд батлагдсанаар үндэсний болон салбарын бодлогын олон олон баримт бичгийг эргэж харах, хуульд нийцүүлэх шаардлага үүсэж, 2017 оноос бүсчилсэн хөгжлийн бодлогыг шинэчлэн боловсруулах ажил эхэлсэн юм. Энэ хүрээнд олон уулзалт, хэлэлцүүлэг хийж, оролцогчдын хүрээ ч өргөн байв. Тухайлбал, Монгол Улсын Ерөнхий сайдын 2017 оны 165 дугаар захирамжаар анхны ажлын хэсгийг байгуулж, 2023 он хүртэл Японы Жайка

зэрэг олон улсын байгууллагууд, дотоод, гадаадын эрдэмтэн судлаачид, мэргэжилтнүүдийн оролцоотойгоор “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ын эхний хувилбарыг боловсруулсан. Мөн Ерөнхий сайдын захирамжаар 2022-2023 онд хот, хөдөөгийн сэргэлтийн ажлын хэсгийг байгуулж, “Монголын эдийн засгийн чуулган”, мөн 21 аймаг, нийслэлд хөрөнгө оруулалтын форум, Бүсчилсэн хөгжлийн урьдчилсан хэлэлцүүлгийг Зүүн, Баруун, Хойд, Хангай, Төв, Говийн

бүс бүрээр мөн зохион байгуулж, нийт 700 орчим оролцогчдоос давхардсан тоогоор 440 гаруй санал зөвлөмж гаргасан нь бодлогыг боловсронгуй болгоход чухал ач холбогдолтой арга хэмжээ болсныг тэмдэглэе.

Бодлогын хувилбарт өргөн хүрээнд, олон талын оролцоог хангасан саналуудыг ийн тусгаснаар үзэл баримтлалын төслийг парламентад өргөн мэдүүлж, 2024 оны зургаадугаар сарын 5-ны өдөр УИХ-ын 64 дүгээр тогтоолоор “Монгол



Д.Эрдэнэбаяр: Монгол Улс 23 жилийн дараа бүсчилсэн хөгжлийн шинэ бодлоготой боллоо.

Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал” батлагдсан. Манай улс ийнхүү 23 жилийн дараа бүсчилсэн хөгжлийн шинэ бодлоготой болсон юм.


-Бүсчилсэн хөгжлийн бодлогыг төдийлөн амжилттай хэрэгжүүлж чадаагүй туршлага манайд бий. Энэ удаагийн бодлогыг амжилттай хэрэгжүүлж чадах болов уу гэдэг бодол хүмүүст байна?

-Бүсийн төлөвлөлт салбарын бодлогын уялдааг хангаагүй, бүсчлэлийг хүн амын нутагшил,

хот байгуулалт, газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан нэгдмэл систем болгон хэрэгжүүлээгүй, хөрөнгө оруулалтын үр дүн, үр ашгийн асуудал орхигдсон, хязгаарлагдмал хөрөнгийг үр ашиггүй тарамдуулах асуудал газар авсан зэрэг олон шалтгаантай. Харин энэ удаа бодлого амжилттай хэрэгжих хэд хэдэн үндэслэл байна гэж харж байна. **Нэгдүгээрт**, урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”-д бүсчилсэн хөгжлийн бодлого бие даасан

бүлэг болж орсон. **Хоёрт**, Засгийн газраас 2024 оныг “Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил” болгон зарласан нь энэ салбарт ажиллаж, судалгаа хийж буй хүмүүсийн хувьд чухал үйл явдал болсон бөгөөд энэ хугацаанд бодлого, эрх зүйн орчны шинэчлэлийг идэвхтэй явуулсан. **Гуравт**, УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийг бүсчилсэн тойргоор явуулсан нь бодлогыг хэрэгжүүлэхэд том түлхэц болох хүлээлттэй байгаа, **Дөрөвт**, олон талын оролцоог хангах замаар бодлогыг дэмжих институцыг бүрдүүлэх ажил идэвхтэй өрнөж байна. Тухайлбал, сая байгуулсан Бүсийн зөвлөлүүд, мөн бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх үндсэн чиг үүрэгтэй манай хүрээлэн ч энэхүү институцийн нэг хэсэг юм. **Тавдугаарт**, бүсчилсэн хөгжлийн бодлого Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн чухал бүрэлдэхүүн хэсэг төдийгүй, нэгдсэн төсвийн бодлогын нэг гол чиглэл нь бүсчилсэн хөгжлийн цогц реформын хэрэгжүүлэхэд чиглэж байна.

Эцэст нь тэмдэглэхэд, улс орны хөгжлийн бодлого зөвхөн төр засгийн хийх ажил биш, төр, иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хамтын ажиллагаа, харилцан дэмжлэг, харилцан ойлголцолд тулгуурладаг онцлогтой. Төр нь хувийн хэвшлээ дэмжиж байж хувийн хэвшлийн үйл ажиллагаа өргөжин тэлж, ажлын байрыг нэмэгдүүлэх замаар ажилгүйдэл, ядуурлыг бууруулдаг. Амьжиргааны чанар нь сайжирсан иргэд, бизнес нь амжилтад хүрсэн хувийн хэвшлийнхэн эргээд улсын эдийн засгийг хөдөлгөх хүч болдог. Ийм учраас бүх салбарт, бүх түвшинд нэгдсэн нэг ойлголттой болж, нэг зүгт харж байж бүсчилсэн хөгжлийн бодлого амжилттай хэрэгжих болно.



МОНГОЛ УЛСЫН БҮСЧИЛСЭН



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ ЗУРГААДУГААР САРЫН 05-НЫ ӨДРИЙН 64 ДҮГЭЭР ТОГТООЛООР "МОНГОЛ УЛСЫН БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ" БАТЛАГДСАН



ХАНГАЙН БҮС

Бүсийн хөгжлийн зорилго нь дэлхий дахинд Монголын түүх, төрт ёс, соёлын өвийг түгээн дэлгэрүүлж, Орхоны хөндий, Хангайн нурууны байгалийн онцлогт тулгуурлан аялал жуулчлал, боловсруулах үйлдвэрлэлийг дагнан хөгжүүлсэн "Дэлхийн нүүдэлчдийн соёлын голомт нутаг, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн бүс" болно.


БАРУУН БҮС

Бүсийн хөгжлийн зорилго нь Төв Азийн орнууд болон ОХУ, БНХАУ-ын зах зээлтэй холбогдож, Дэлхийн өв Увс нуурын сав, Монгол Алтайн нуруу-Хангайн нурууны байгалийн унаган төрх, олон үгсаатны түүх, соёлын өвд түшиглэсэн тусгай сонирхлын аялал жуулчлалаар төрөлжиж, мал аж ахуй, газар тариалангийн нөөцөд тулгуурлан эко үйлдвэрлэлийн хоршилт бүхий "Тогтвортой хөгжлийн бүс" болно.



ХОЙД БҮС

Бүсийн хөгжлийн зорилго нь Оросын Холбооны Улс болон Европын орнуудтай эдийн засгийн харилцааг өргөжүүлж, Хөвсгөл нуур, Сэлэнгэ мөрний сав газрын эко систем, байгаль, түүх, соёлын өвд тулгуурлан аялал жуулчлал, амралт сувилал, хүнд үйлдвэрлэлээр төрөлжсөн "Аялал жуулчлал, аж үйлдвэрлэлийн хөгжлийн бүс" болно.



Эрхэм зорилго

Үндэсний соёлоо дээдэлсэн, байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалан хойч үедээ өвлүүлсэн, эдийн засгийн төрөлжилт, дагналт, хоршилт бүхий ногоон үйлдвэрлэлийг хөгжүүлж, бүс нутгийн эдийн засгийн интеграцад нэгдсэн, хүн амын нутагшилт, суурьшлын тогтвортой тогтолцоотой, өрсөлдөх чадвартай бүсийг харьцангуй тэнцвэртэйгээр хөгжүүлнэ.

Бүсчлэлийн тогтолцоо

Монгол Улсыг Хангайн, Баруун, Хойд, Төвийн, Зүүн, Говийн, Улаанбаатарын гэсэн бүсчлэлийн тогтолцоогоор хөгжүүлнэ. Бүсэд дараах аймаг, хот хамаарна:

- Хангайн бүсэд - Архангай, Баянхонгор, Өвөрхангай аймаг;
- Баруун бүсэд - Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд аймаг;
- Хойд бүсэд - Булган, Орхон, Хөвсгөл аймаг;
- Төвийн бүсэд - Дархан-Уул, Сэлэнгэ, Төв аймаг;
- Зүүн бүсэд - Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймаг;
- Говийн бүсэд - Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь аймаг;
- Улаанбаатарын бүсэд - Нийслэл Улаанбаатар хот ба түүний дагуул хотууд.



БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫГ ДАРААХ ҮЕ ШАТТАЙГААР ХЭРЭГ ЖҮҮЛНЭ:


- I ҮЕ ШАТ: 2024-2030 ОН;
- II ҮЕ ШАТ: 2031-2040 ОН;
- III ҮЕ ШАТ: 2041-2050 ОН.

ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

ТӨВИЙН БҮС


Бүсийн хөгжлийн зорилго нь олон улстай эдийн засгийн харилцааг өргөжүүлж, тээвэр логистикийн нэгдсэн сүлжээнд холбогдож, уламжлалт мал аж ахуй болон эрчимжсэн хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэлээр төрөлжиж, дотоодын хэрэгцээгээ бүрэн хангасан

"Эрүүл хүнс үйлдвэрлэгч, экспортлогч бүс" болно.



ЗҮҮН БҮС

Бүсийн хөгжлийн зорилго нь Зүүн Хойд Азийн орнуудтай эдийн засгийн харилцааг өргөжүүлж, Хан Хэнтийн нуруу, Дорнод Монголын байгалийн экосистем, Дэлхийн өв Бурхан халдун, Эзэн Чингис хааны төрт ёс, түүх, соёлын өвд түшиглэсэн аялал жуулчлал, уламжлалт болон эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан, уул уурхайн боловсруулах үйлдвэрлэлээр төрөлжсөн "Олон улсын худалдаа, тээвэр, логистикийн таталцлын бүс" болно.




ГОВИЙН БҮС

Бүсийн хөгжлийн зорилго нь Бүгд Найрамдах Хятад Ард Улс болон Өмнөд Азийн орнуудтай эдийн засгийн харилцааг өргөжүүлж, өндөр технологи бүхий уул уурхай, хүнд үйлдвэрлэлээр дагнан төрөлжсөн говийн унаган байгаль, түүх, соёлын өв, палеонтологийн нөөцөд түшиглэн аялал жуулчлал хөгжсөн "Үндэсний баялгийн санг бүрдүүлэгч бүс" болно.



УЛААНБААТАРЫН БҮС

Бүсийн хөгжлийн зорилго нь Төв болон Зүүн Хойд Азийн орнуудтай эдийн засгийн харилцааг өргөжүүлж, хүн ам, үйлдвэрлэл, үйлчилгээ, байгаль орчны зохистой бүтэцтэй, 20 минутын үйлчилгээний хүртээмжтэй төвүүд бүхий хот болж "Олон улсын банк, санхүү, бизнесийн хөгжлийн төв" болно.



Бүсүүдийн хөгжлийн зорилго, зорилт

Бүсүүдийн хөгжлийн нийтлэг зорилго:

- Бүс нутгийн хөгжлийн орчин үеийн онолын чиг хандлагад үндэслэнэ;
- Бүс нутгийн онцлог, давуу талыг нээн илрүүлнэ;
- Бүс, орон нутгийн эдийн засгийн чиг үүргийг оновчтой тодорхойлно;
- Байгалийн нөөц баялгийг зохистой, өгөөжтэй, хүртээмжтэй ашиглаж, хамгаалж, нөхөн сэргээнэ;
- Үйлдвэр, үйлчилгээг хоршилт, төрөлжилт, дагналт, кластерын бодлогоор дэмжинэ;

- Бүс, орон нутагт өндөр технологи, инновацыг нэвтрүүлнэ;
- Бүс дамнасан, салбар хоорондын уялдааг хангасан стратегийн төслүүдийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ;
- Улсын төсвийн хөрөнгө оруулалт, гадаад зээл, тусламж, орон нутгийн төсөв, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хөрөнгө оруулалт болон бусад эх үүсвэрийг оновчтой хуваарилна;
- Татвар, санхүүгийн ялгаатай бодлогыг хэрэгжүүлнэ;
- Бүс нутгийн хөгжилд оролцогч талуудын хамтран ажиллах сонирхлыг дэмжинэ;
- Тээвэр логистикийн нэгдсэн сүлжээ, боомт, чөлөөт бүс, тусгай бүсийг хөгжүүлнэ;
- Дэд бүтцийн нэгдсэн, ухаалаг сүлжээг байгуулна;
- Бүс нутгийн эдийн засгийн интеграцад нэгдэн, зах зээлийг тэлнэ;
- Орчин үеийн шинэ суурьшлын бүс, хотуудыг байгуулна;
- Бүс нутгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулна;
- Орон нутагт ажиллаж, амьдрах, бизнес эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлсэн өрсөлдөх чадвартай бүсүүдийг хөгжүүлнэ.

ХАНГАЙН БҮС

Дэлхий дахинд Монголын түүх, төрт ёс, соёлын өвийг түгээн дэлгэрүүлж, Орхоны хөндий, Хангайн нурууны байгалийн онцлогт тулгуурлан аялал жуулчлал, боловсруулах үйлдвэрлэлийг дагнан хөгжүүлсэн "Дэлхийн нүүдэлчдийн соёлын голомт нутаг, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн бүс" болно.



АРХАНГАЙ АЙМАГ,
ХОРГЫН ТОГОО

БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ





**ШИНЭ
ХАРХОРУМ ХОТ**

БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

” УЛАМЖЛАЛТ МАЛ АЖ АХУЙН ТӨРӨЛЖСӨН,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ДЭД БҮС ”

ХЭРЭГЖҮҮЛЭХ
ТОМООХОН ТӨСӨЛ,
ХӨТӨЛБӨРҮҮД

ХАНГАЙН БҮС

ШИНЭ ХАРХОРУМ ХОТ

Орхоны хөндийд нийслэлийн баримжаатай Шинэ Хархорум хотыг байгуулж, засаглалын төвлөрлийг зохицуулна.

Шинэ Хархорум хотод сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор хотхоныг байгуулна.

Шинэ Хархорум хотод “Орхоны хөндий” өндөр технологи, инновац, бизнес хөгжлийн төв байгуулна.

Шинэ Хархорум хотод бүсийн тээвэр, логистикийн төв байгуулна.

СОЁЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУСГАЙ БҮС, ГЕОПАРК

Орхон голын сав, Хангайн нурууны экосистемд түшиглэсэн түүх, соёл, рашаан сувиллын аялал жуулчлалыг уламжлалт, сэргээн засах анагаах ухаантай уялдуулан хөгжүүлнэ

Өвөрхангай аймагт Өндөр гэгээн Занабазарын бүтээл, соёлын өвд тулгуурлан соёлын аялал жуулчлал, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжинэ.

Архангай аймгийн Өгийнуур орчимд археологийн нөөцөд тулгуурлан “Төв Азийн түүх, соёлын голомт” соёлын аялал жуулчлалын цогцолборыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулна.



НИЙТ 29 ТӨСӨЛ

Тээвэр
логистикийн

8

Хот байгуулалт, боомт,
бүтээн байгуулалтын

7

Соёл, аялал
жуулчлалын

6

Боловсрол,
эрүүл мэндийн

4

Эрчим
хүчний

4

Үйлдвэр
үйлчилгээний

2



Улаанбаатар хот-Шинэ Хархорум хот-Улиастай хот чиглэлийн 500 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барина.



Шинэ Хархорум хотод 4Е ангиллын нисэх буудал байгуулна.

ХҮНД ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПАРК

Хангайн бүсэд нүүрс-эрчим хүч, металл боловсруулах үйлдвэрийг бусад дагалдах үйлдвэрийн хамт байгуулах хувийн хэвшлийг дэмжинэ.

Өвөрхангай аймагт бүсийн бүтээн байгуулалтын хэрэгцээг хангах барилгын материалын хангамжийн төв байгуулна.

ВАРЧУН БҮС

Төв Азийн орнууд болон Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын зах зээлтэй холбогдож, дэлхийн өв Увс нуурын сав, Монгол Алтайн нуруу-Хангайн нурууны байгалийн унаган төрх, олон угсаатны түүх, соёлын өвд түшиглэсэн тусгай сонирхлын аялал жуулчлалаар төрөлжиж, мал аж ахуй, газар тариалангийн нөөцөд тулгуурлан эко үйлдвэрлэлийн хоршилт бүхий “Тогтвортой хөгжлийн бүс” болно.



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ,
АЛТАНЦӨГЦ СУМ

An aerial photograph of a large, deep blue reservoir situated in a vast, arid desert landscape. The water body is surrounded by sandy, brownish terrain with some sparse vegetation. In the distance, low mountains and a clear blue sky with scattered clouds are visible. The text 'БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ' is overlaid in white, bold, uppercase letters on the left side of the image, followed by a horizontal white line extending to the right.

БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

An aerial photograph showing a large concrete dam structure built across a deep, narrow canyon. The dam is surrounded by rugged, brown, rocky terrain. A winding road or canal runs along the base of the dam. In the background, a vast, deep blue reservoir stretches across a wide valley, bordered by distant, hazy mountains under a bright blue sky with scattered white clouds. A white horizontal line is positioned to the left of the text.

ТАЙШИРЫН УСАН ЦАХИЛГААН СТАНЦ

БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

” ЭРЧИМ ХҮЧНИЙ ТӨРӨЛЖСӨН,
БАЙГАЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ДЭД БҮС ”

ХЭРЭГЖҮҮЛЭХ
ТОМООХОН ТӨСӨЛ,
ХӨТӨЛБӨРҮҮД

БАРУУН БҮС

СОЁЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУСГАЙ БҮС, ГЕОПАРК

Монгол Алтайн нуруу, Хангайн нуруу, Увс нуурын ай сав, их нууруудын экосистемд түшиглэсэн байгалийн адал явдалт, тусгай сонирхлын, хил орчмын аялал жуулчлалын тусгай бүс байгуулна.

Ховд аймгийн Эрдэнэбүрэн суманд Монгол Алтайн нурууны байгаль, соёлын өвд түшиглэсэн эко парк байгуулна.

ЭРЧИМ ХҮЧ

Ховд аймгийн Ховд гол дээр эрчим хүчний нэгдсэн системийн горим тохируулах үүрэг бүхий Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын хүчин чадалтай усан цахилгаан станц барина.

Говь-Алтай аймагт 15 МВт-ын хүчин чадалтай нарны цахилгаан станц барина.

Баруун бүсэд эрчим хүчний нэгдсэн системийн горим тохируулах үүрэг бүхий 100 МВт хүртэл хүчин чадалтай усан цэнэгт цахилгаан станц барина.

Баруун бүсэд эрчим хүчний нэгдсэн системийн суурь ачаалалд ажиллах 100 МВт хүртэл хүчин чадалтай дулааны цахилгаан станц барина.

Завхан аймагт 30 МВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станц барина.

Бүсийн хэмжээнд шаардлагатай 500 кВ, 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барина.

ХӨНГӨН, ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК

Ховд аймагт бүсийн хөнгөн үйлдвэрлэл, технологийн парк байгуулах хувийн хэвшлийг дэмжинэ.



НИЙТ 38 ТӨСӨЛ

Тээвэр
логистикийн

9

Хот байгуулалт, боомт,
бүтээн байгуулалтын

7

Соёл, аялал
жуулчлалын

4

Боловсрол,
эрүүл мэндийн

5

Эрчим
хүчний

9

Үйлдвэр
үйлчилгээний

4



Увс, Ховд аймгийн
нисэх буудлыг 4С
ангиллын болгон
өргөтгөнө.

ТЭЭВЭР ЛОГИСТИКИЙН ТӨВ, ХУУРАЙ БООМТ, ХИЛИЙН БООМТ

Ховд хотод бүсийн тээвэр, логистикийн төв байгуулж,
түүнд түшиглэн хуурай боомт байгуулна.

Булган, Арцсуурь, Бургастай боомтуудын зэрэглэлийг
ахиулж, нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

ХҮНД ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПАРК


Говь-Алтай аймагт барилга, уул уурхайн салбарын хэрэгцээг
хангах дэвшилтэт технологийн шохойн болон магнезитийн
үйлдвэрийг байгуулах хувийн хэвшлийг дэмжинэ.

Ховд аймагт бүсийн бүтээн байгуулалтын хэрэгцээг хангах
барилгын материалын хангамжийн төв байгуулна.

ХОЙД БҮС

Оросын Холбооны Улс болон Европын орнуудтай эдийн засгийн харилцааг өргөжүүлж, Хөвсгөл нуур, Сэлэнгэ мөрний сав газрын эко систем, байгаль, түүх, соёлын өвд тулгуурлан аялал жуулчлал, амралт сувилал, хүнд үйлдвэрлэлээр төрөлжсөн “Аялал жуулчлал, аж үйлдвэрлэлийн хөгжлийн бүс” болно.



 ХӨВСГӨЛ АЙМАГ
ХӨВСГӨЛ ДАЛАЙ

БҮСЧИЛСЭН
ХӨГЖИЛ 53

БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ





ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР

БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

” БАЙГАЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТӨРӨЛЖСӨН, АЖ ҮЙЛДВЭРИЙН ДЭД БҮС ”

ХЭРЭГЖҮҮЛЭХ
ТОМООХОН ТӨСӨЛ,
ХӨТӨЛБӨРҮҮД

СОЁЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУСГАЙ БҮС, ГЕОПАРК

Бүсийн байгаль, газарзүйн онцлогийг харгалзан хил орчмын болон хил дамнасан аяллыг хөгжүүлж, Хөвсгөл нуурын экосистемийн нөөцөд түшиглэсэн аялал жуулчлалын тусгай бүсийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулна.

Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд “Цэнхэр сувд” байгалийн шинжлэх ухааны музейн цогцолбор байгуулна.

ЭРЧИМ ХҮЧ

Булган аймгийн Эгийн голд эрчим хүчний нэгдсэн системийн горим тохируулгын үндсэн эх үүсвэр 310 МВт-ын хүчин чадалтай усан цахилгаан станц барина.

Хөвсгөл аймгийн нисэх буудлыг 4С ангиллын болгон өргөтгөнө.

Мөрөн хотод бүсийн дата төв байгуулна



Бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан аймгуудын мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг төрөлжүүлж, Хөвсгөл, Булган аймагт салбар дундын дадлага, үйлдвэрлэлийн бааз байгуулна.

НИЙТ 22 ТӨСӨЛ

Тээвэр
логистикийн

5

Хот байгуулалт, боомт,
бүтээн байгуулалтын

5

Соёл, аялал
жуулчлалын

4

Боловсрол,
эрүүл мэндийн

5

Эрчим
хүчний

1

Үйлдвэр
үйлчилгээний

2



Орхон аймагт бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан “Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор”-ыг байгуулна.

ТЭЭВЭР ЛОГИСТИКИЙН ТӨВ, ХИЛИЙН БООМТ

Эрдэнэт хотод бүсийн тээвэр, логистикийн төв байгуулна.

Ханх, Бага-Илэнх боомтуудыг өргөжүүлж, нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлнэ.


ХҮНД ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПАРК

Орхон аймагт зэс боловсруулах, металлурги-химийн үйлдвэр болон бусад дагалдах үйлдвэр бүхий үйлдвэрлэл, технологийн парк байгуулна.

ТӨВИЙН БҮС

Олон улстай эдийн засгийн харилцааг өргөжүүлж, тээвэр логистикийн нэгдсэн сүлжээнд холбогдож, уламжлалт мал аж ахуй болон эрчимжсэн хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэлээр төрөлжиж, дотоодын хэрэгцээгээ бүрэн хангасан “Эрүүл хүнс үйлдвэрлэгч, экспортлогч бүс” болно.



 ТӨВ АЙМАГ
АГЛАГ БҮТЭЭЛИЙН ХИЙД



БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ



ГАЗАР ТАРИАЛАН

БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

” ХӨДӨӨ АЖ АХУЙН ТӨРӨЛЖСӨН,
АЖ ҮЙЛДВЭРИЙН ДЭД БҮС ”

ХЭРЭГЖҮҮЛЭХ
ТОМООХОН ТӨСӨЛ,
ХӨТӨЛБӨРҮҮД

ЧӨЛӨӨТ БҮС

ХӨШИГИЙН ХӨНДИЙ ЧӨЛӨӨТ БҮС

Олон улсын санхүүгийн төв, аялал жуулчлалын цогцолбор, мэдээлэл технологийн кластер зэрэг тэргүүлэх чиглэлээр хөгжүүлнэ.

ХУУРАЙ БООМТ

Алтанбулаг, Хөшигийн хөндийн чөлөөт бүсэд ачаа тээвэр, барилгын материалын логистикийн төвийг түшиглэн хуурай боомт байгуулна.

СОЁЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУСГАЙ БҮС, ГЕОПАРК

Туул голын сав, Богдхан уулын экосистемд түшиглэсэн олон улсын арга хэмжээ, хотын аяллыг хөгжүүлэх Хөшигийн хөндийн аялал жуулчлалын тусгай бүс байгуулна.

“КИНО, КОНТЕНТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЦОГЦОЛБОР”

Хөшигийн хөндийд байгуулах сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолборыг түшиглэн “Кино, контент үйлдвэрлэлийн цогцолбор”-ыг байгуулна.

ХӨНГӨН, ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК

Дархан-Уул аймагт бүсийн хөнгөн, хүнсний үйлдвэрлэл, технологийн парк байгуулах хувийн хэвшлийг дэмжинэ.



НИЙТ 34 ТӨСӨЛ



Тээвэр
логистикийн

7

Хот байгуулалт, боомт,
бүтээн байгуулалтын

6

Соёл, аялал
жуулчлалын

4

Боловсрол,
эрүүл мэндийн

5

Эрчим
хүчний

7

Үйлдвэр
үйлчилгээний

5



Бүсийн эрчим хүчний хангамжийн
эх үүсвэр болох дулааны цахилгаан
станц барина.

ХҮНД ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПАРК

ДАРХАН - ГАН БОЛОВСРУУЛАХ ЦОГЦОЛБОР

металл боловсруулах болон металл бүтээгдэхүүний
үйлдвэр, дагалдах үйлдвэр бүхий үйлдвэрлэл,
технологийн парк байгуулна.

СЭЛЭНГЭ - ХӨТӨЛИЙН ҮТП

металл бус эрдэс бодисоор хийсэн бүтээгдэхүүний
үйлдвэр, бусад дагалдах үйлдвэр бүхий үйлдвэрлэл,
технологийн парк байгуулна.

ЗҮҮН БҮС


Зүүн Хойд Азийн орнуудтай эдийн засгийн харилцааг өргөжүүлж, Хан Хэнтийн нуруу, Дорнод Монголын байгалийн экосистем, Дэлхийн өв Бурхан халдун, Эзэн Чингис хааны төрт ёс, түүх, соёлын өвд түшиглэсэн аялал жуулчлал, уламжлалт болон эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан, уул уурхайн боловсруулах үйлдвэрлэлээр төрөлжсөн “Олон улсын худалдаа, тээвэр, логистикийн таталцлын бүс” болно.



ДОРНОД АЙМАГ
БУЙР НУУР

БҮСЧИЛСЭН
ХӨГЖИЛ 65

БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ





**АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛ**

БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

” ТҮҮХЭН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТӨРӨЛЖСӨН,
ЭРЧИМЖСЭН ХӨДӨӨ АЖ АХУЙН ДЭД БҮС ”

ХЭРЭГЖҮҮЛЭХ
ТОМООХОН ТӨСӨЛ,
ХӨТӨЛБӨРҮҮД
ЗҮҮН БҮС

СОЁЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУСГАЙ БҮС, ГЕОПАРК

Дорнод аймагт түүх, соёлын нөөц, Буйр нуурыг түшиглэсэн хил орчмын болон хил дамнасан аяллыг хөгжүүлэх аялал жуулчлалын тусгай бүс байгуулна.

Сүхбаатар аймгийн Дарьганга суманд тахилгат хайрхан уулс, түшиглэсэн байгаль, соёлын өвийн цогцолбор байгуулна.

Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн Бурхан халдун, Буйр нуур, Алтан Овоо зэрэг түүхэн дурсгалт газруудыг холбосон аялал жуулчлалын дэд бүтцийг байгуулна.

Дорнод аймагт бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан “Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор”-ыг байгуулна.



ХУУРАЙ БООМТ

Чойбалсан хот, Бичигт боомтын тээвэр, логистикийн төвийг түшиглэн хуурай боомт байгуулна.



НИЙТ 29 ТӨСӨЛ

Тээвэр
логистикийн

6

Хот байгуулалт, боомт,
бүтээн байгуулалтын

7

Соёл, аялал
жуулчлалын

6

Боловсрол,
эрүүл мэндийн

5

Эрчим
хүчний

2

Үйлдвэр
үйлчилгээний

3



Дорнод
аймгийн нисэх
буудлыг 4С
ангиллын
болгон
өргөтгөнө.

ХИЛИЙН БООМТ

Эрээнцав, Сүмбэр, Хавирга, Бичигт
боомтуудын зэрэглэлийг ахиулж,
нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

ХҮНД ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПАРК

Зүүн бүсэд кокс, химийн бүтээгдэхүүн болон нүүрс-эрчим хүчний
үйлдвэр, бусад дагалдах үйлдвэр бүхий үйлдвэрлэл, технологийн
парк байгуулах байгуулна.

ГОВИЙН БҮС

Бүгд Найрамдах Хятад Ард Улс болон Өмнөд Азийн орнуудтай эдийн засгийн харилцааг өргөжүүлж, өндөр технологи бүхий уул уурхай, хүнд үйлдвэрлэлээр дагнан төрөлжсөн, говийн унаган байгаль, түүх, соёлын өв, палеонтологийн нөөцөд түшиглэсэн аялал жуулчлал бүхий “Үндэсний баялгийн санг бүрдүүлэгч бүс” болно.



ӨМНӨГОВЬ АЙМАГ
НЭМЭГТ, ХЭРМЭН ЦАВ

БҮСЧИЛСЭН
ХӨГЖИЛ



БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ





ОЮУТОЛГОЙ

БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

” АЖ ҮЙЛДВЭРИЙН ТӨРӨЛЖСӨН,
НОГООН ЭРЧИМ ХҮЧНИЙ ДЭД БҮС ”

ХЭРЭГЖҮҮЛЭХ
ТОМООХОН ТӨСӨЛ,
ХӨТӨЛБӨРҮҮД

СОЁЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУСГАЙ БҮС, ГЕОПАРК

Дундговь аймгийн Цагаансуварга орчимд палеонтологийн нөөцөд түшиглэсэн аялал жуулчлалын тусгай бүсийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулна.



ТЭЭВЭР ЛОГИСТИКИЙН ТӨВ, ХУУРАЙ БООМТ

Даланзадгад, Чойр хотуудад бүсийн тээвэр, логистикийн төв байгуулж, түүнд түшиглэн хуурай боомт байгуулна.

Замын-Үүд хотын эдийн засгийн чөлөөт бүсэд барилгын материал, түүхий эдийн импортын хангамж, логистикийн төвийг байгуулна.



Өмнөговь аймгийн нисэх
буудлыг 4D ангиллын
болгон өргөтгөнө



АЙМАГ, СУМЫН БҮСЧИЛСЭН НОГООН ХӨГЖЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР

Орон нутгийн хөгжлийн төвүүдэд хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэлийг дэмжих инженерийн дэд бүтэц, үйлчилгээ, худалдаа, бирж, тээвэр, логистикийн цогцолборыг кластераар хөгжүүлнэ.

ТӨВИЙН БҮС

НИЙТ 38 ТӨСӨЛ

Өмнөговь аймагт бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан “Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор”-ыг байгуулна.



Говийн бүсийг усаар хангах “Орхон-Онги”, “Хэрлэн тооно” төслийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Тээвэр
логистикийн

9

Хот байгуулалт, боомт,
бүтээн байгуулалтын

8

Соёл, аялал
жуулчлалын

5

Боловсрол,
эрүүл мэндийн

5

Эрчим
хүчний

6

Үйлдвэр
үйлчилгээний

5

ЭРЧИМ ХҮЧ

Өмнөговь аймагт Тавантолгойн 450 МВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станц барина.

Нар, салхины тус бүр 100 МВт хүртэл хүчин чадалтай цахилгаан станц барина.

ХИЛИЙН БООМТ

Гашуунсухайт, Шивээхүрэн, Ханги боомтуудын зэрэглэлийг ахиулж, нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлнэ

ХҮНД ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПАРК

Өмнөговь аймагт нүүрс-эрчим хүч болон металлургийн кокс, бусад дагалдах үйлдвэр бүхий үйлдвэрлэл, технологийн парк байгуулна.

Дорноговь аймгийн Алтанширээт суманд газрын тосны бүтээгдэхүүн, химийн үйлдвэрийг бусад дагалдах үйлдвэрийн хамт байгуулна.

Говийн бүсэд хүнд үйлдвэрлэл, технологийн парк байгуулах хувийн хэвшлийг дэмжинэ.

УЛААНБААТАРЫН БҮС

Төв болон Зүүн Хойд Азийн орнуудтай эдийн засгийн харилцааг өргөжүүлж, хүн ам, үйлдвэрлэл, үйлчилгээ, байгаль орчны зохистой бүтэцтэй, 20 минутын үйлчилгээний хүртээмжтэй төвүүд бүхий хот болж “Олон улсын банк, санхүү, бизнесийн хөгжлийн төв” болно.



УЛААНБААТАРЫН БҮС

20 МИНУТЫН ХОТ



- Ахмад настнуудын өдөр тутмын орон зай
- Хүүхэд, багачуудын өдөр тутмын орон зай
- Насанд хүрэгчдийн өдөр тутмын орон зай

Нийслэл Улаанбаатар хотыг дараах 14 хотод хуваан бие даан хөгжүүлнэ. Үүнд:-Хан-Уул хот-Яармаг хот-Буянт-Ухаа хот-Сонгинохайрхан хот-Толгойт хот-Баянхошуу хот-Өнөр хот-Баянгол хот-Чингэлтэй хот-Сэлбэ хот-Сүхбаатар хот-Дарь-Эх хот-Баянзүрх хот-Амгалан хот,Эдгээр хотод иргэн бүр төрийн үйлчилгээг 20 минут дотор авахаар их өгөгдөлд тулгуурласан цахим төлөвлөлт бүхий нэгдсэн стандарт тогтоох юм.

НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТЫГ

14 ХОТОД
ХУВААН

БИЕ ДААН ХӨГЖҮҮЛНЭ



БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

“ ОЛОН УЛСЫН БАНК, САНХҮҮ,
БИЗНЕСИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ БҮС НУТАГ ”

УЛААНБААТАРЫН БҮС

ЧӨЛӨӨТ БҮС

“НАЛУУ-УХАА” ЭДИЙН ЗАСГИЙН ТУСГАЙ БҮС

Олон улсын тээвэр логистик,
импортыг орлох барилгын материалын
үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээг
кластераар хөгжүүлнэ.

“АГРОСИТИ” ЭДИЙН ЗАСГИЙН ТУСГАЙ БҮС

45,000 тонн нарийн ногоо хураах
өвлийн хүлэмжийн кластер бүхий
Агросити эдийн засгийн тусгай бүсийн
үйл ажиллагааг эхлүүлнэ.

ЭКО АЖ ҮЙЛДВЭРИЙН ПАРК

Малын гаралтай түүхий эдийн анхан шатны
боловсруулалтын түвшнийг сайжруулж
нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний
үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх “Эмээлт эко аж
үйлдвэрийн парк”-ийг байгуулна.

“НҮҮДЭЛЧИН” ДЭЛХИЙН СОЁЛЫН НААДАМ ТУСГАЙ БҮС

Бүсийн хөгжлийн зорилго нь Төв болон Зүүн Хойд Азийн орнуудтай эдийн засгийн харилцааг өргөжүүлж, хүн ам, үйлдвэрлэл, үйлчилгээ, байгаль орчны зохистой бүтэцтэй, 20 минутын үйлчилгээний хүртээмжтэй төвүүд бүхий хот болж “Олон улсын банк, санхүү, бизнесийн хөгжлийн төв” болно.



НИЙТ 29 ТӨСӨЛ

Тээвэр
логистикийн

2

Хот байгуулалт, боомт,
бүтээн байгуулалтын

8

Соёл, аялал
жуулчлалын

3

Боловсрол,
эрүүл мэндийн

3

Эрчим
хүчний

5

Үйлдвэр
үйлчилгээний

8



УЛААНБААТАР
ХОТЫН "ШИНЭ
ИХ ТОЙРУУ"
ХУРДНЫ ЗАМ



ХӨШИГИЙН
ХӨНДИЙН
ТУННЭЛ



Улаанбаатар хотын
дулааны цахилгаан
станцуудыг
шинэчлэн, хүчин
чадлыг нэмэгдүүлнэ.



ХҮНД ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПАРК

БАГАНУУР ХОТОД хүнд үйлдвэрлэл, технологийн парк байгуулна.

БАГАХАНГАЙ ДҮҮРЭГТ эрдэс, түүхий эдийн нөөцөд тулгуурлан зах зээлийн эрэлтийг хангах шилний үйлдвэрийг байгуулна.



Иргэд, олон нийтийн санал

БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО-БҮСИЙН ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН

УИХ, орон нутгийн сонгуулийн дараа шинэ төр засаг байгуулагдаж, бодлого төлөвлөгөөгөө гаргаад ажилдаа шуурхайлан орсон. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд байгуулагдсан Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэнгээс “Бүсчилсэн хөгжил-Шинэ стандарт” үндэсний форумыг зохион байгуулсан юм.

Энэ нь УИХ, Засгийн газар болон орон нутгийн удирдлагууд шинээр томилогдсонтой холбоотойгоор энэхүү форумыг хийж, бүсчилсэн хөгжлийн талаарх ойлголтын зөрүүг арилгах, нэгдсэн нэг ойлголтоор цаашид хөгжих зорилгыг агуулж

байв. Тус форумд төр, хувийн хэвшил, олон улсын байгууллага, 21 аймаг, 100 гаруй сумын төлөөлөл, нийтдээ 1800 орчим оролцогчидтойгоор 7 бүсээр 20 гаруй хэлэлцүүлэг өрнүүлсэн.

Засгийн газрын 2024-2028 онд хэрэгжүүлэх хамгийн гол бодлого бол Бүсчилсэн хөгжил юм. Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ “Манай Засгийн газар ирэх дөрвөн жилд Бүсчилсэн хөгжлийн бодлогод хамгийн түрүүнд анхаарч ажиллана” гэж онцолсон.

Өнгөрсөн 30 жил төр, засгийн бодлого, хэрэгжүүлэлтэд буруу зөрүү ойлголт, мэдээллүүд гарч, үүнээс үүдэн төрийн бодлогын залгамж

алдагдах, хэрэгжилт удаашрах зэрэг олон асуудал үүсэж байсныг бид мэднэ. Тиймээс Засгийн газар үндэсний хэмжээний том бодлого хэрэгжүүлэхийн өмнө Бүсчилсэн хөгжлийн талаар бодлого тодорхойлогчид, хувийн хэвшил, олон улсын байгууллага, орон нутгийн удирдлагуудад тодорхой мэдээ мэдээлэл өгч, ойлголтыг нэгтгэхийг зорьж байна.

Шадар сайд С.Амарсайхан Бүсчилсэн хөгжлийн бодлого ямар зорилготой, хэрхэн хэрэгжих талаарх гол илтгэл тавьж, илтгэлийн агуулгаа маш энгийнээр дараах байдлаар томьёолсон юм.



Үүнд:

- *Орон нутгийн эдийн засгийн өсөлтийг тэлж, урагшлуулах*
- *Хүн амаа зөв байршуулж, ажлын байрыг нэмэгдүүлэх*
- *Тэгш, хүртээмжтэй, тогтвортой хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх*
- *Амьдралын чанарыг шинэ стандартаар хэрэгжүүлсэн орон нутгийг хөгжүүлэх*
- *Баялгаа тэгш, хүртээмжтэйгээр хуваарилах*
- *Хувийн хэвшлийн итгэлийг сэргээж, идэвхийг хангана*

Тус илтгэл мөн Монгол Улс ирэх 30 жилийн хөгжлийн энэ загвараа шинэ стандартаар хөгжүүлэх ёстой. Стандарт хаана байна, тэнд хөгжил, аюулгүй байдал, сэтгэл ханамж байдаг. Тиймээс орон нутгийг олон улсын жишиг, шинэ стандартаар хөгжүүлэхийн ач холбогдлыг ойлгуулахад чиглэж байлаа.

Түүнчлэн төр, засгаас Бүсчилсэн хөгжлийн бодлогыг эрчимтэй явуулахын тулд тодорхой тогтоол, шийдвэрүүдийг гаргаж, холбогдох яам, байгууллагуудын удирдлагад даалгасан.

Тухайлбал, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны нэгдүгээр сарын 14 болон нэгдүгээр сарын 22-ны хуралдаан, мөн оны Бүсчилсэн хөгжлийн Үндэсний хорооны хоёрдугаар сарын 03-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор “Бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаан”, бүсийн хамтын ажиллагааг дэмжих, идэвхжүүлэх олон талт арга хэмжээ”-г зохион байгуулахаар шийдвэрлэсэн. Бүсүүдийн хамтын ажиллагааг дэмжих, идэвхжүүлэх, хөдөлгөөн өрнүүлэх хүрээнд олон талт арга хэмжээг зохион байгуулахыг Засгийн газар, аймаг нийслэлийн Засаг дарга нарт даалгасан байгаа.

Тус албан шийдвэрүүдийн дагуу Бүсүүдийн зөвлөлийг бүс бүрд байгуулах бөгөөд аймгуудын Засаг дарга нар цагаан толгойн үсгийн дарааллаар нэг нэг жилээр ээлжлэн уг зөвлөлийг даргалах юм.

Бүсийн зөвлөлийн гол зорилго нь бүсчилсэн хөгжлийн бодлогыг дэмжиж ажиллах, тухайн бүсийн хөгжлийн төлөвлөгөөг гаргаж, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, идэвхжүүлэх үүрэгтэй болно. Энэхүү зөвлөл нь тухайн бүсээс сонгогдсон

УИХ-ын гишүүд, бүх шатны ИТХ, Засаг дарга нарын төлөөлөөс бүрдэх юм.

Мөн Засгийн газрын тогтоолын хүрээнд бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдааныг бүс бүрд зохион байгуулах, бүсүүдийн 2040 он хүртэлх ерөнхий төлөвлөгөөг бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд боловсруулах, бүс бүрд хэрэгжүүлэх 5 тэргүүлэх төслийг тодорхой болгох, мөн Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгад санал авахаар ажиллаж байна.

Бүсчилсэн хөгжил хөдөлгөөнийг бүсүүдэд өрнүүлнэ

Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн “Бүсчилсэн хөгжил” хөдөлгөөний хүрээнд иргэд олон нийт, инженерүүдийн дунд “Шинэ бүтээл- оновчтой санаа”, оюутан, судлаачид, залуучуудын дунд “Шинжлэх ухааны нийтлэл, Оюутны хакатон” тэмцээнийг зохион байгуулна. Мөн, орон нутгийн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид болон хувийн хэвшлийнхний дунд газарзүйн заалттай орон нутгийн онцлог, брэнд бүтээгдэхүүнийг тодорхойлох арга хэмжээ, Ерөнхий боловсролын сурагчдын дунд эсээ бичлэгийн уралдаан мөн түүнчлэн бүсийн иргэдийн спортын наадам, бүсчилсэн хөгжил- хамтын шийдэл хэлэлцүүлэг зэрэг арга хэмжээг бүс бүрд зохион байгуулж, үр дүнг нэгтгэн Засгийн газарт тухай бүрт нь тайлагнаж ажиллаж байна.

Бүсчилсэн хөгжлийн бодлогыг дагасан олон талт хөдөлгөөн, арга хэмжээг бүс бүрд зохион байгуулснаар хөгжлийн энэхүү шинэ загвар бодит хөрсөнд бууж, иргэд олон нийт тодорхой ойлголт мэдээлэлтэй болох ач холбогдолтой. Энэ нь хөгжлийн бодлогыг эрчимжүүлэн хэрэгжүүлэхэд томоохон нөлөө үзүүлэх юм.



БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 33 дугаар тогтоолоор “Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн” нь Монгол Улсын Шадар сайд (бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал эрхэлсэн)-ын эрхлэх асуудлын хүрээнд үүсгэн байгуулагдсан.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Үндэсний соёлоо дээдэлсэн, байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалан хойч үедээ өвлүүлсэн, эдийн засгийн төрөлжилт, дагналт, хоршилт бүхий ногоон үйлдвэрлэлийг хөгжүүлж, бүс нутгийн эдийн засгийн интерацид нэгдсэн, хүн амын нутагшилт суурьшлын тогтвортой, тогтолцоотой, өрсөлдөх чадвартай бүсийг харьцангуй тэнцвэртэйгээр хөгжүүлнэ.

ХҮРЭЭЛЭНГИЙН ЧИГ ҮҮРЭГ

Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн нь Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, бүсүүдийн хөгжлийн хөтөлбөр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад оролцогч байгууллага, салбарын үйл ажиллагааны уялдааг хангах, шинжлэх ухааны үндэслэлтэй дэмжлэг, туслалцаа үзүүлэх үндсэн чиг үүрэг бүхий байгууллага юм.

ХҮРЭЭЛЭН НЬ ДОРХ ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД ДАРААХ ЧИГЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛНЭ

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх чиглэлээр төрийн болон холбогдох бусад



"Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн"-гийн хамт олон

байгууллагын үйл ажиллагааг улсын хэмжээнд үялдуулахад мэргэжлийн дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

Бүсүүдийн хөгжлийн хөтөлбөр, дунд хугацааны бодлогын баримт бичиг боловсруулах, хэрэгжүүлэхэд шаардлагатай бодлогын хувилбар судалгаа, шинжилгээний ажлыг зохион байгуулж, цахим мэдээллийн сан бүрдүүлж, эрхлэн хөтлөх, мэдээлэх;

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд батлагдах хууль тогтоомжийн төсөл боловсруулахад оролцох, бодлого, төлөвлөлтийн нийцэл, үялдааг хангах чиглэлээр санал хүргүүлэх, хэлэлцүүлэг зохион байгуулах ажлыг хариуцан хэрэгжүүлэх;

Бүсчилсэн хөгжлийн хүрээнд хэрэгжиж буй урт, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийн

үр дүнд үндэслэн цаашид төлөвлөлтийг хэрэгжүүлэхэд шаардагдах, хөрөнгө болон хүний нөөцийн талаар санал гаргаж холбогдох байгууллагад уламжлах;

Төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, орон нутгийн захиргааны байгууллагаас хэрэгжүүлж байгаа бүсчилсэн хөгжлийн талаар үйл ажиллагааны үр дүнг нэгтгэн үнэлэлт, дүгнэлт өгч Монгол Улсын Шадар сайдад тайлагнах;

Бүсчилсэн хөгжлийн бодлого хэрэгжүүлэхэд холбогдох бодлогын судалгаа төсөл, хөтөлбөрийн ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах ажлыг зохион байгуулах, хэрэгжилтийг хангах;

Бүсчилсэн хөгжлийн бодлого, хэрэгжилтийн талаар олон нийтэд таниулах, сурталчлах үйл ажиллагааг эрхлэн явуулах юм.